

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар
2010



**СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ДҮҮЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТАНД
ХҮЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

УЛААНБААТАР
2010

АЖЛЫН ХЭСЭГ

Боловсруулсан:

Е.Батчулуун, АББЗСҮТ-ийн захирал
З.Тогтохмаа, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
Б.Эрдэнэчимэг, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн

Оролцсон:

Ю.Алтантуяа, БСШУЯ-ны ХШҮГ-ын мэргэжилтэн
Р.Арсланбат, СБД-ийн АББ-ын ГХТ-ийн захирал
Б.Батсүрэн, СХД-ийн АББ-ын ГХТ-ийн захирал
Ц.Баяржаргал, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
С.Болормаа, БСШУЯ-ны ЕБГ-ын мэргэжилтэн
Б.Болорчимэг, НҮБ-ын ХС-ийн Боловсролын хөтөлбөрийн ажилтан
Д.Гүндэгмаа, Судлаач
Г.Идэржаргал, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
Н.Монголмаа, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн менежер
Б.Мөнхбаяр, АДРА ОУБ-ын Боловсролын хөтөлбөрийн ажилтан
Ж.Нарантуяа, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Р.Намжилдагва, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
Ё.Нямдаваа, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн ажилтан
Д.Оюунсүрэн, БГД-ийн АББ-ын ГХТ-ийн захирал
Ж.Оюунцэцэг, ХУД-ийн АББ-ын СҮТ-ийн захирал
Б.Халиун, НҮБ-ын Хүүхдийн сангийн АББ хариуцсан мэргэжилтэн
Т.Хантулга, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
С.Ундрал, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн
Х.Чинтогтох, АББЗСҮТ-ийн мэргэжилтэн

Зөвлөсөн:

Ё.Нямдаваа, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн ажилтан

Эх бэлтгэсэн:

Ц.Баяржаргал

ӨМНӨХ ҮГ

Нийгэм, эдийн засгийн олон талт шалтгааны улмаас боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй хүүхэд, залуус, насанд хүрэгчдэд сурах хоёрдагч боломж олгох зорилгоор “*ЪАйль—э'jmj'£ jруй'*” — *—р<а'т*ыг явуулж эхэлснээс хойш өдгөө 10 орчим жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд уг сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, эрхзүйн баримт бичиг, сургалтын материал хэдэн арваар гарч тогтолцоо бүрдсэнээр АББ-ын үйлчилгээний нэг чиглэл болон хөгжиж байна. Цаашид чанар, хүртээмжийг улам нэмэгдүүлэх үүднээс уг сургалтын хүрээнд гарсан ахицтай болон бэрхшээлтэй асуудлууд, тэдгээрийг шийдэх хувилбарын хамт тусгасан дүн шинжилгээ бүхий энэхүү тайланг боловсруулан гаргаж байгаа юм.

Энэхүү материалыг бодлого боловсруулагчид, энэ чиглэлээр судалгаа хийдэг байгууллага, хүмүүс болон сонирхсон бүхий л хүнд зориулсан бөгөөд та бүхний хэрэгцээг хангана гэдэгт найдаж байна.

Хүний сурч боловсрох үндсэн эрхийг хангах замаар амьдралын чанарыг дээшлүүлэх нь глобаль зорилт билээ.

БСШУЯ-ны харьяа

Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв

ТОВЧИЛСОН ҮГ

АББ	Албан бус боловсрол
АББЗСҮТ	Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСГ	Боловсрол, соёлын газар
ГТ	Гэгээрлийн төв
ДХС	Дүйцсэн хөтөлбөрийн сургалт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ХШҮГ	Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (БСШУЯ-ны хэлтэс)

ГАРЧИГ

УДИРТГАЛ	6
1. СУРГАЛТЫН ЭРХЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ	7
1.1. Бодлого, эрх зүйн орчин бүрдсэн байдал	8
1.2. Бодлогын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд	11
2. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ	12
2.1. Үндэсний түвшин дэх бүтэц, төрийн байгууллагын үүрэг, оролцоо	13
2.2. Бусад байгууллагын үүрэг, оролцоо	14
2.3. Сургалтын санхүүжилт	15
3. СУРГАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН САН	18
3.1. Мэдээллийн сангийн удирдлага, зохион байгуулалт	19
3.2. Дүйцсэн сургалтын талаарх мэдээллийн үндсэн үзүүлэлт	20
3.3. Мэдээллийн сангийн ашиглалт, тулгарч буй асуудлууд	23
4. СУРГАЛТЫН АГУУЛГА, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН	24
4.1. Сургалтын агуулга	25
4.2. Сургалтын арга зүй	26
4.3. Сургалтын материалын нэр төрөл, хүрэлцээ, хангамж	27
5. СУРГАЛТЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ	29
5.1. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч	37
5.2. Сургалтын орчин	40
5.3. Эцэг эх, орон нутгийн дэмжлэг	45
5.4. Сургалтын үр дүн, төгсөгчид	45
6. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	47
6.1. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын хүрсэн үр дүн	49
6.2. Тулгамдаж буй асуудлууд, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж	49

УДИРТГАЛ


Даяарчлал, үндэсний эрх ашгийн нэгдлийг ханган тогтвортой хөгжих, мэдээлэл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нэмэгдэх, мэдлэг, мэдээлэл, дэвшилтэт технологи нь эдийн засгийн үндсэн нөөц болох чиг хандлага бүхий шинэ зууны нийгэмд ажиллаж амьдрах хүүхэд, залууст боловсролыг уян хатан, хувилбарт хэлбэрээр олгож болох талаар Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлд “Монгол улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ”, 8 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлд “Иргэн нь боловсролыг албан ба албан бус сургалтаар эзэмшиж болно” хэмээн тус тус заасан байна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд “АББ-ын судалгаа арга зүйн байгууллага” ажиллах талаар Боловсролын хууль (заалт 17.2)-д заасны дагуу 1997 онд байгуулагдсан “Албан бус боловсролын төв” (хуучин нэрээр)-өөс Азийн бүсийн бусад орнуудын туршлагыг судлан тэдний явуулдаг зарим үйл ажиллагаанаас шилжилтийн үед байсан Монгол орны нөхцөл байдал тохирох заримыг нь авч хэрэгжүүлж эхэлсний нэг нь энэхүү “дүйцсэн хөтөлбөрийн сургалт” юм. Энэ нь тухайн үеийн нийгэм-эдийн засгийн онцлогтой холбоотой үүссэн хурц асуудлын нэг болоод байсан сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох ажлыг шийдвэрлэх эхний алхам байсан билээ. Одоо энэ нь нэгэнт АББ-ын салбарын үндсэн ажлын нэг болон өргөжиж боловсролын хүртээмжийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн энэхүү үзэл санааны хүрээнд бага, дунд боловсролыг шинэчлэн хөгжүүлэх, түүний чанарыг сайжруулах зорилгоор боловсролын үйлчилгээний үйл явц, үр дүнд нэгдсэн шаардлага тавьж стандартчилж өгсөн нь албан ба албан бус сургалтын хэлбэрүүдийн үйл явц, үр дүнг хооронд нь дүйцүүлэн авч үзэх боломжийг бүрдүүлсэн билээ.

АББ-ын үйлчилгээний хамгийн өргөн хүрээг хамарсан хэлбэр нь дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн олгож буй сургалт бөгөөд энэ үйлчилгээг хүртэгч гол зорилтот бүлэг нь боловсролгүй буюу ямар нэг шатны сургуульд хамрагдан суралцаж байгаагүй эсвэл сургалтын хөтөлбөрөө дуусгалгүйгээр сургууль завсардсан хүүхэд, залуус, насанд хүрэгчид юм. Дүйцсэн хөтөлбөр нь энэхүү зорилтот бүлэгт суралцах хоёрдогч боломж олгож, бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгоход чиглэгдэж байна. Энэ сургалтын чиглэл сүүлийн жилүүдэд харьцангуйгаар өргөжих хандлага ажиглагдаж байгаа нь эрх зүй орчин, санхүүжилт тодорхой хэмжээгээр шийдэгдэж байгаатай нягт холбоотой.


Дүйцсэн хөтөлбөрөөр суурь боловсрол олгож буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үнэлэх, цаашид суурь боловсрол эзэмших хүний үндсэн эрхийг бүрэн хангах арга замыг тодруулах зорилгоор энэхүү ажлыг хийж байна.



**СУРГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ХЭРЭГЖИЛТ**

I.1. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН БАЙДАЛ

I.2. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД



I.I. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН БАЙДАЛ

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагааны удирдамж болгоход чиглэсэн бодлогын хэд хэдэн баримт бичиг гарч хэрэгжиж байна. Эдгээр нь үндсэндээ дүйцсэн хөтөлбөрийн сургалтын талаар авсан шат дараалсан арга хэмжээ юм:

- 1997 онд Засгийн газраас баталсан “АББ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т 6 үндсэн зорилт дэвшүүлсний нэг нь сургуулийн гадна буй болон сургууль завсардсан хүүхэд залууст боловсрол нөхөн олгох чиглэл байсан юм. Энэ нь дүйцсэн сургалтын талаарх дараа дараачийн бодлого, эрх зүйг тодорхойлох үндэс нь болж өгсөн бөгөөд хөтөлбөрийн энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд Ази-Номхон далайн орнууд дахь дүйцсэн сургалтын туршлагыг судлах, Монголын нөхцөл байдалд тохирсон агуулга арга зүйг боловсруулах ажил эхэлжээ.
- Эдгээр судалгааны ажлын үр дүнд боловсруулсан “Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр”-нь Гэгээрэл (хуучин нэрээр)-ийн сайдын 2001 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан бөгөөд энэ нь сургууль завсардсан болон сургуулийн гаднах хүүхэд залууст боловсрол нөхөн олгох үйлчилгээг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн түлхэц өгсөн чухал баримт бичиг болсон юм. Энэ хөтөлбөрийн дагуу дүйцсэн хөтөлбөрийн бага болон суурь боловсролын сурах бичгүүдийг боловсруулан гаргасан нь өнөө хүртэл хэрэглэгдэж байна.
- 2003 оноос цогц чадамжид суурилсан Боловсролын шинэ стандартыг мөрдөх болсонтой холбогдуулан 2001 онд батлагдсан “Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр”-ийг дахин шинэчлэн сайжруулах шаардлага гарсан билээ. Энэхүү хөтөлбөрийн агуулга, бүтцийг Боловсролын стандарттай уялдуулан, боловсролын бүх түвшинг хамрахаар шинэчлэн боловсруулж, “Бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр” болгон БСШУ-ны сайдын 2005 оны 358 дугаар тушаалаар баталсан нь одоо баримталж буй үндсэн баримт бичиг юм. Энэ хөтөлбөрийн өмнөхөөсөө ялгагдах гол онцлог нь боловсролын стандартад тулгуурлан цогц чадамжид суурилсан модулан бүтэцтэй болсноос гадна зөвхөн бага, суурь боловсрол төдий биш, бүрэн дунд боловсролын түвшинг хамарч байгаа болно (Хүснэгт 1.1).

Хүснэгт 1.1. 2001 ба 2005 оны дүйцсэн сургалтын хөтөлбөрийн ялгаа

Бага, суурь боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр (2001 он)	“Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөр” (2005 он)
Бага, суурь боловсролын түвшин (8 дугаар анги хүртэл)	Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин
Хичээлд суурилсан бүтэцтэй	Модулан бүтэцтэй
Бага боловсролын 2, суурь боловсролын 5 сурах бичиг	46 нь бага, 45 нь суурь, 23 нь бүрэн дунд боловсрол
Мэдлэгт төвлөрсөн	Цогц чадамжид суурилсан

- Засгийн газрын түвшинд гарсан бодлогын баримт бичиг болох 2006 оны 192 тогтоолоор батлагдсан “Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-ний “АББ ба насанд хүрэгчдийн боловсрол” дэд салбарын хүрээнд авч үзсэн үндсэн 3 тэргүүлэх чиглэлийн нэг болох “Сургуулийн гадна байгаа хүүхэд, залуус болон сургууль завсардагчдыг албан бус боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд дүйцсэн хөтөлбөрийн сургалтын хүртээмж, чанар, менежментийн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой тусгасан байна. Мастер төлөвлөгөөний зорилтын хэрэгжилтийг дүгнэж, 2009 оноос дахин шинэчилж буй хувилбарт дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх, дүйцсэн сургалтын тогтолцоог институтчлах зэрэг томоохон зорилтуудыг тусгасан нь 2015 он хүртэл энэ чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол чиглэл болж байна (Хүснэгт 1.2).

Хүснэгт 1.2. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүн болон шалгуур үзүүлэлт (Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар, 2010-2015)

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Үр дүн ба шалгуур үзүүлэлт
1.2.1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтын материал, багш нарын гарын авлагын нэр төрөл, хэлбэрийг олшруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх 1.2.2. Дүйцсэн сургалтын модулиудыг онлайн хэлбэрт шилжүүлж, цахим-сургалтын материал боловсруулан ашиглах, нээлттэй суралцах боломжийг нэмэгдүүлэх стратегийн эх үндсийг буй болгох 1.2.3. Дүйцсэн сургалтад хамрагдаж буй нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тооцохдоо орон нутгийн онцлог ба инфляцийн түвшинтэй уялдуулан, хуваарилалтыг нэмэгдүүлж, үр ашигтай зарцуулах 1.2.4. Дүйцсэн сургалтад хамрагдаж буй 15 хүртэлх насны хүүхдийг дотуур байраар ханган суралцах боломжийг бүрдүүлэх	• Дүйцсэн сургалтыг онлайн хэлбэрээр явуулж, үр дүнг туршсан байна. • Сургуулийн гадна буй хүүхэд залуусын 40.0 хувь нь дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж, сургуулийн насны суралцагчдын 10-аас доошгүй хувийг нь ерөнхий боловсролын сургуульд шилжүүлсэн байна. • Дүйцсэн сургалтад хамрагдаж буй эмзэг бүлгийн 12 хүртэлх насны суралцагчид үдийн цайнд хамрагдах зохицуулалт хийгдсэн байна. • Хөдөө орон нутагт дүйцсэн сургалтад хамрагдаж буй 15 хүртэлх насны хүүхдийг дотуур байраар хангадаг болсон байна. • Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад олгох хувьсах зардлыг инфляцитай уялдуулан нэмэгдүүлж, санхүүжилтийг хүрэлцээтэй болгосон байна. • Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр хичээл заах багш нарт зориулсан гарын авлага материал бэлтгэгдэнэ.
2.1.1 Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийж, агуулга, арга зүйг улам боловсронгуй болгох 2.1.2 Холимог бүлгийн сургалтын онол, арга зүйг боловсронгуй болгож, АББ-ын тогтолцоонд нэвтрүүлж, үнэлгээ хийх 2.1.3 Онлайн болон зайны сургалтын материал боловсруулах мэргэжилтний чадавхи дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх 2.1.4 Дүйцсэн сургалтын арга зүйг албан болон албан бус боловсролын багш нарт эзэмшүүлэхэд зориулсан гарын авлага, зөвлөмжийг боловсруулан ашиглах	• Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж, сургалтын модулийг турших загвар төв 10-ыг байгуулна. • АББ-ын багш нар холимог бүлгийн сургалтын арга зүйд суралцаж, гэрчилгээ авсан байна. • Тогтвортой хөгжлийн, эрүүл мэндийн, эрх зүйн гэх мэт боловсролыг иргэд, хүн амд албан бус хэлбэрээр олгоход чиглэгдсэн сургалтын хөтөлбөр болон сургалтын материалууд гарч хэрэглэгдэж эхэлсэн байна.
3.1.1 Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн олгох сургалтыг институтчилах тогтолцоог бүрдүүлэх	• Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн байдлыг баталгаажуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

- 2006 онд батлагдсан Боловсролын хуулинд дүйцсэн хөтөлбөрийн талаар тусгайлсан хэд хэдэн заалт нэмж орсон нь дээрх эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр дүн байсан билээ. Энэ нь тодорхой хугацааны боловсролыг дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар нөхөн олгож болохыг анх хуульчилж өгсөнөөрөө онцлогтой. Түүнчлэн энэ хуулийн заалтын дагуу дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад улсын төсвөөс хувьсах зардал олгож эхэлдэг болсон нь энэ сургалт төдийгүй албан бус боловсролын салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхам болсон билээ.

2006 оны 12 дугаар сард шинэчлэн батлагдсан “Боловсролын тухай хууль”-д орсон нэмэлт заалтууд:

8.2: “Тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даан эзэмших зорилгоор бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болох бөгөөд уг хөтөлбөрийн агуулга, сургалт явуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”,

40.2: “Төрийн өмчит бүх шатны сургуулийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нийт зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарим хэсэг, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох сургалтын нормативт зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ”

- Боловсролын тухай багц хууль (2006)-ийн 8.2, 40.2 дугаар заалтыг хэрэгжүүлэх, дүйцсэн хөтөлбөрийн сургалтад тавих шаардлага, оролцох талуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, санхүүжилтийг үр ашигтай зарцуулах зорилгоор “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ыг боловсруулсан нь БСШУ-ны сайдын 2007 оны 362 тоот тушаалаар батлагдсан байна. Уг журам нь:

1. Нийтлэг үндэслэл
2. Сургалтын зохион байгуулалт
3. Сургалтын баримт бичиг
4. Сургалтын хэлбэр, хугацаа
5. Сургалтын хяналт-шинжилгээ, үнэлгээ
6. Санхүүжилт

гэсэн үндсэн бүлэгтэй бөгөөд сургалтын байгууллага, орчин, хяналт үнэлгээ, баримтжуулалт зэрэг боловсрол нөхөн олгох дүйцсэн сургалт явуулахад тавигдах бүхий л шаардлагыг тодорхой заасан байна.

- 2008 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон мөн онд Засгийн газраас баталсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх¹ болон бичиг үсэгт тайлагдалтын түвшинг дээшлүүлэх зэрэг заалтууд нь мөн л дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг дэмжсэн хэмээн үзэж болно.
- Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасны дагуу гаргасан “Боловсрол” үндэсний хөтөлбөрт дүйцсэн сургалтын асуудал нэлээд дэлгэрэнгүй туссан байна.

¹ Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, УБ., 2008
Стратегийн зорилт 1


Ийнхүү дээр дурдсан бодлогын баримт бичиг, эрх зүйн актууд нь дүйцсэн хөтөлбөрийн сургалтын талаар шат дараалсан арга хэмжээ болж, сургалтын энэхүү дэд тогтолцоо өнгө төрхөө олоход ихээхэн түлхэц өгсөн гэж хэлж болно.

I.2. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

.....


Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх тал дээр зохих хэмжээнд амжилт олсон ч бодлогын хэрэгжилт газар дээрээ хангалтгүй байгааг дараах хэд хэдэн зүйлээр тодруулъя:

- Хууль эрх зүй нь орон нутгийн түвшинд хэрэгжих механизм болж хараахан чадаагүй байна: Жишээ нь: 2008 онд гарсан “Суурь боловсрол эзэмших насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулахад баримтлах чиглэл”-д: албан бус боловсролын үйлчилгээний чадавхи, эрх зүйн орчин нь албан сургалтын үйлчилгээтэй хослон ажиллах түвшинд хүрээгүй явдал нь суурь боловсрол эзэмших насны хүүхдийн багагүй хувь нь сургуулийн гадна байсаар байх шалтгаан болж байгаа юм. Сум, багийн засаг дарга нар сургууль завсардалтыг бууруулах, иргэдийнхээ боловсролыг дэмжих талаар тодорхой үүрэг хүлээх талаар Боловсролын тухай хуульд орсон олон заалт хэрэгжихгүй байна. Орон нутгийн удирдлагын зүгээс АББ-ын ажилд дэмжлэг үзүүлэх байдал төдийлөн хангалттай бус байна.
- Санхүүжилтийн хувьд шийдэгдээгүй асуудал олон байна. Ялангуяа АББ-ын багш нарын албан тушаалын ангилал зэрэглэл, цалин хөлсний сүлжээнд хамрагдсан байдал бие даасан байдлаар нэг мөр болоогүй байгаа нь хүндрэлтэй байна. Жишээ нь: Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, зэрэглэл тогтоох тухай 2007 онд гарсан Засгийн Газрын 354 дүгээр тогтоолд АББ-ын багш нарын цалинг тусад нь ангилалд оруулаагүйгээс тухайн ажил олгогч болон сургуулийн удирдлагын хандлагаас хамаарч, ихэнх газар давхар ажил хариуцуулснаас сургалтын үр дүн, ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.
- АББ-ын багш нь Боловсролын хуульд заасны дагуу багшийн нийгмийн халамжийн талаарх заалтад хамрагдах бололцоо хаалттай байна. Сургуульд ажилласан багш 6 жил тутамд нэмэгдэл урамшуулал авдаг, тэтгэвэрт гарах үедээ 18 сарын цалинтай тэнцэх мөнгөн тусламж нэг удаа авдаг бол АББ-ын багшид энэ нь олгогдохгүй байгаа билээ.



СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ

- 2.1. ҮНДЭСНИЙ ТҮВШИН ДЭХ БҮТЭЦ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**
- 2.2. БУСАД БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**
- 2.3. СУРГАЛТЫН САНХҮҮЖИЛТ**



Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг хангах замаар бага насны бүх хүүхдэд суурь боловсрол олгох дэлхийн зорилтыг хангахад олон байгууллага, хувь хүмүүсийн идэвхтэй оролцоо, манлайлал чухал үүрэгтэй билээ.

Дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүргийг доорх хүснэгтээр тодруулан гаргаж байна (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1. Дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллагуудын оролцоо

Байгууллагуудын нэр	Гүйцэтгэх үүрэг
Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Бодлогын шийдвэр гаргах, зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх,
Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв	Бодлогын бичиг баримт боловсруулан БСШУЯ-нд хүргүүлэх, сургалтын материал бэлтгэх, боловсруулах, сургалт зохион байгуулах, хэрэгцээг судлах, үнэлэх
Боловсролын хүрээлэн	Дүйцсэн хөтөлбөрийн кирриклим, агуулга, аргазүй, сургалтын материал боловсруулахад оролцох
Аймгийн Боловсрол, соёлын газар	Орон нутгийн түвшинд дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
Сумын АББ-ын Гэгээрлийн төв	Зорилтот бүлгийг хамруулсан дүйцсэн хөтөлбөрийн сургалт зохион байгуулах
Боловсролын их сургууль, түүний харьяа Багшийн сургууль	Багшаар бэлтгэгдэж буй оюутнуудад дүйцсэн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүйг эзэмшүүлэх
Хандивлагч байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд	Сургалтын материал бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх
Олон улсын болон үндэсний ТББ-ууд	Сургуулийн гадна байгаа хүүхдүүдэд зориулсан бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг дэмжих

Доор дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон бусад байгууллагын үүрэг, оролцоо ямар тус тусад авч үзье.

2.1. ҮНДЭСНИЙ ТҮВШИН ДЭХ БҮТЭЦ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

.....

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь **А'ЛБэ—'уй тА%оуу'ЛБ** боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Боловсрол, соёл шинжлэх ухааны яам (БСШУЯ) болон түүний харьяанд ажиллах Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв (АББЗСҮТ), **ай"«уй' тА%оуу'ЛБ** засаг даргын дэргэдэх Боловсрол соёлын газар, — **"ЛБААр<уй'тА%оуу'ЛБ** засаг дарга буюу АББ-ын Гэгээрэл төв гэсэн дараалалтай гэж үзэж болно. Бүтэц тус бүрийн холбогдох үүрэг, функцийг товч дурдъя:

- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй болон сургалтын зохион байгуулалт, холбогдох бодлого боловсруулах ба хэрэгжилтэнд хяналт тавих, зохицуулах асуудлыг БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газар хариуцаж буй бөгөөд сургалтын мэдээ, мэдээлэл нь Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт нэгтгэгдэж байна.

- АББЗСҮТ нь дүйцсэн хөтөлбөрийн агуулга болон дүйцсэн сургалтын материал боловсруулах, түгээх, үндэсний түвшинд багш боловсон хүчнийг бэлтгэх, холбогдох хууль эрхзүйн баримт бичгийн санал боловсруулан БСШУЯ-нд хүргүүлэх, дүйцсэн сургалттай холбоотой мэдээллийг цуглуулж, боловсруулах, орон нутагт мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үүргийг хүлээдэг.
- Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт харъяалагддаг байгууллага болох Боловсрол, Соёлын газарт дүйцсэн сургалтыг орон нутагт зохион байгуулах, холбогдох бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. АББ хариуцсан мэргэжилтэн нь сумдын АББ-ын төвийн багш нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд зориулсан сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөх, аймгийн хэмжээний тайлан мэдээг нэгтгэх, үнэлгээ дүгнэлт хийх ба БСШУЯ, АББЗСҮТ-өөс хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг гүйцэтгэж байна.
- Дүйцсэн сургалтыг “гардан” зохион байгуулдаг гол газар нь сум, дүүргүүдэд буй Гэгээрлийн төв юм. Одоогоор албан ёсны бүртгэлтэй 358 Гэгээрлийн төвийн 10 (Улаанбаатар хотын 9 дүүрэг, Орхон аймгийн төвд) нь бие даасан статустай, бусад нь сургууль түшиглэн ажиллаж байна. Эдгээр төв харъяа газрынхаа суралцагчдыг бүртгэх, дүйцсэн сургалтад хамруулах, сургалт зохион байгуулах үүргийг хүлээдэг.

2.2. БУСАД БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

.....

Дүйцсэн хөтөлбөрийн хэрэгжилтэнд олон улсын хандивлагч байгууллага, үндэсний ТББ-ууд нэлээд чухал үүрэг гүйцэтгэж байна. Эдгээр нь сургууль завсардсан, ядуу, эмзэг бүлгийн хүүхдийг төрөл бүрийн шатны сургалтад хамруулах замаар завсардалтыг бууруулж, боловсролын хүртээмжийг дээшлүүлэх, багш, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, материаллаг бааз, сургалтын орчныг сайжруулах, бодлогод нөлөөлөх зэргээр үйл ажиллагаа явуулдаг. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн зөнгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Хүүхдийг ивээх сан (Англи) зэрэг олон улсын, “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан”, “Хүүхдийн эрхийн төв”, “Тэгш мөр” зэрэг үндэсний ТББ-ыг энд дурьдаж болно.

Үүнээс гадна “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-д зааснаар шаардлага хангасан хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага ДХС-ыг зохион байгуулж болох талаар оруулсан билээ. Энэ нь төрийн байгууллагын ачааллыг хөнгөвчлөх, ДХС-ын хүртээмжийг нэмэгдүүлэх улмаар сургалтыг либералчлах давуу талтай боловч үйл явцыг удирдан зохицуулах механизм одоо болтол тодорхойгүй байна. Тухайлбал, зөвшөөрөл өгөх эрх бүхий байгууллага тодорхойгүй, санхүүжилтийг шийдвэрлэх ойлголт шат шатандаа хангалтгүй байна. Одоогоор ДХС-ыг явуулах хүсэлтэй байгаа байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүс байгаа ч дээрх тодорхойгүй асуудлаас хамааран үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байгаа юм.

2.3. СУРГАЛТЫН САНХҮҮЖИЛТ

2006 онд “Боловсролын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орж бага, дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчийн хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлэхээр заасантай² холбогдуулан суралцагчдын тооноос хамаарсан тодорхой хэмжээний зардлыг 2008 оноос эхлэн олгож эхэлсэн юм. Төсвийн гүйцэтгэлийн зорилтот түвшний эдгээр үзүүлэлтийг баримжаалан 2007-2008 оны хичээлийн жилд суралцагчийн хувьсах зардалд зориулан 1.2 тэрбум, 2009 онд 1.5 тэрбум тус тус зарцуулсан ба 2010 онд 1,8 тэрбум төг зарцуулахаар төлөвлөжээ.

Боловсролын салбарын мастер төлөвлөгөөнд тусгагдсанаар дүйцсэн хөтөлбөрийн хувьсах зардалд 2008-2011 онд жил бүр дунджаар 1.2 тэрбум төгрөг, 2012-2015 онд жил бүр дунджаар 1.7 тэрбум төгрөг байхаар төлөвлөж байна. Дүйцсэн сургалтын модуль, сургалтын материал, гарын авлага, багшид зориулсан зөвлөмж бэлтгэхэд 2008-2011 онд жилд дунджаар 176 сая төгрөг, 2012-2015 онд жилд 193 сая төгрөг шаардагдахаар тусгажээ.

ДХС-ын энэхүү санхүүжилт нь БСШУЯ-наас аймаг, нийслэлийн БСГ-аар дамжин орон нутагт хуваарилагдаж, газар дээрх зарцуулалтыг сургуулийн захирал хариуцдаг байна. Санхүүжилтийн ихэнх нь АББ-ын багш нарын цалин ба нийгмийн даатгалын шимтгэлд, үлдсэн багахан хэсэг нь орон нутагт сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.

ДХС-ын санхүүжилтийг Увс, Ховд, Архангай аймаг дээр жишээлж үзье. Увс аймагт 2008 онд 1089, 2009 онд 1146 хүүхдээр бодож ДХС-ын хувьсах зардал олгогдсон ба үүнээс АББ-ын багш нарын цалин, НДШ, дүйцсэн сургалтын мэргэжлийн хичээл заасан багш нар (ЕБС-ийн мэргэжлийн багш)-ын цагийн хөлсийг олгож үлдсэн хэсгийг багуудад сургалт зохион байгуулах, бензин шатахуун зэрэгт зарцуулжээ. Тус аймгийн БСГ-ын мэргэжилтэн Г.Болор-Эрдэнэ одоогоор санхүүжилтийн хувьд бэрхшээлтэй асуудал төдийлөн бага байгааг дурдаж байв.

Харин Архангай аймгийн хувьд 2009 онд ДХС-нд 458 хүүхэд хамрагдсан боловч 352 хүүхдэд хувьсах зардал олгогджээ (42 сая төг). Энэ нь мөн л АББ-ын багшийн цалинд зарцуулагдсан ба цалингийн доод хэмжээ нь 108 000 төг, дээд хэмжээ нь 220 000 төгрөг байсан байна. 2010 онд тус аймгаас 611 хүүхдийг ДХС-д хамруулахаар БСШУЯ-д хүргүүлсэн боловч хасагдан 50 сая орчим төгрөгийн санхүүжилт олгохоор болсон хэмээн аймгийн БСГ-ын АББ хариуцсан мэргэжилтэн Б.Билэгт ярьсан болно.

БСШУЯ-наас гаргадаг санхүүжилтийн хуваарилалтад ДХС-аас гадна “Хичээл практикийн зардал” гэсэн ангилалд багахан мөнгө тусгагддаг ч энэ нь орон нутгийн түвшинд бараг олгогдохгүй байх нь элбэг.

² МУ-ын Боловсролын тухай хууль, 40.2

Үүний шалтгаан нь тухайн аймгийн БСГ-ын удирдлага, АББ-ын мэргэжилтний ажлын туршлага, үйл ажиллагаа, сургуулийн удирдлагын зүгээс АББ-ын салбарт хандах хандлага, дэмжлэг зэрэг олон зүйлээс шалтгаалдаг.

Эндээс үзэхэд ДХС-д хамрагдах суралцагчдад олгох хувьсах зардал нь үндсэндээ АББ-ын багшийн цалинд зарцуулагдаж байгаа хэмээн үзэж болно. АББ-ын цалинг ихэнх газар Засгийн газраас тогтоосон цалингийн зэрэглэлийн дагуу “ТҮБД-5” ангиллаар олгож байгаа бөгөөд энэ нь дунджаар 219 000 төг болж байна (Увс аймгийн жишээн дээр). Зарим газар суралцагчдын тоог “хий өсгөж” өгөх оролдлого их гардаг гэсэн үүднээс зөвхөн АББ-ын ажилласан жил, туршлага зэргийг харгалзан цалин олгодог тал ч байна.

Жишээ нь: Ховд аймгийн БСГ-ын санхүү хариуцсан мэргэжилтний гаргасан төсвийн задаргаан дахь “АББ-ын үйлчилгээ” бүтээгдэхүүний анги дахь “Дүйцсэн хөтөлбөрөөр бага, дунд боловсрол олгох үйлчилгээ” хэсэгт тусгаснаар аймгийн ихэнх сумдад АББ-ын багшийн цалинд 2,9 сая төг (сарын цалин 244000 төг), НДШ-д 322,1 мян төг, бусад хувьсах зардалд 106,4-203,0 мян төг хуваарилсан бол Эрдэнэбүрэн суманд эдгээр нь тус бүр 1,29 сая (сард 108 000 төг), 142,6 мян, 53,5 мян ногдож байна (Хүснэгт 4.2).

Хүснэгт 2.2. Ховд аймгийн зарим сумын ДХС-ын санхүүжилтийн задаргаа

№	Сум	Багшийн цалин	Багшийн цалингийн НДШ	Бусад хувьсах зардал
1	Алтай	2928,0	322,1	203,3
2	Булган	5856	644,2	433,8
3	Эрдэнэбүрэн	1296	142,6	53,5

ДХС-ын санхүүжилтийн энэхүү зарцуулалтаас үзэхэд, сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зардал маш бага байгаа нь харагдаж байна.

- Багш нар дүйцсэн хөтөлбөрийн суралцагчдыг таньдаг, англи хэл, хөгжим, технологийн хичээлийг ЕБС-ийн багш нар заадаг. Хүүхдүүд эдгээр багш нарын хичээллүүлдэг дугуйланд бас явдаг. Англи хэлний үндэсний хөтөлбөрийн дагуу англи хэлний багшаар хэдэн хүүхэд ч байсан заалгадаг, хамрагдсан хүүхдийн тоог хөтөлбөрийн хэрэгжилтэд бичдэг. Түүнээс биш ЕБС-ийн багш нарт нэмэлт цагийн хөлс байхгүй, сайн дураар хамтарч ажилладаг идэвхтэн Алтанцэцэг амьдрах ухааны сургалтад заримдаа заадаг, түүнийг хувиараа л хааяа урамшуулдаг.


*Дорнод аймгийн Баян-Уул сумын
АББ-ын Гэгээрлийн төвийн багш Ж.Ичинхорлоогийн ярианаас..(2010, 3 сар).*

- Мэргэжлийн багш нарт цалин хөлсийг нэмэлтээр олгох нь ховор, тиймээс багш нар дургүйцэх хандлага бий.

*Баян-Өлгий аймгийн Толбо сумын
АББ-ын Гэгээрлийн төвийн багш Т.Ардагериин ярианаас... (2010, 3 сар)*


Иймээс ДХС-ын хувьсах зардлыг тооцох итгэлцүүрийг өөрчлөх замаар санхүүжилтийг нэмэгдүүлэх, түүний зарцуулалтанд хяналт тавих механизмыг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна. Нөгөөтэйгүүр, АББ-ын Гэгээрэл төвийн багш дан ганц дүйсэн сургалтаас гадна бичиг үсгийн болон амьдрах ухааны бусад сургалт зохион байгуулах, АББ-ын бусад үйл ажиллагааг орон нутагт хариуцах үүрэг хүлээдэг боловч уг ажлын цалинг ДСХ-ийн хувьсах зардлаар нөхөж байгаа хэрэг юм.

Энэ байдал нь АББ-ын үйл ажиллагаанд нөлөөлж, зөвхөн цалин авдаг үйл ажиллагааг л сургууль, орон нутгийн зүгээс дэмжиж бусдыг анхаарлын гадна орхих хандлага нэмэгдэх, АББ-ын үйлчилгээг зөвхөн сургууль завсардсан хүүхдэд боловсрол олгодог гэх хүрээнд ойлгох явдал дээд, доод аль ч шатанд газар авахад нөлөөлж байна.




МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**
- 3.2. ДҮҮЦСЭН СУРГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ҮНДСЭН
ҮЗҮҮЛЭЛТ**
- 3.3. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АШИГЛАЛТ, ТУЛГАРЧ БҮҮ
АСУУДЛУУД**



3.1. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

АББ-ын мэдээллийн тогтолцоо нь “доороос дээш” гэсэн чиглэлтэй буюу анхан шатны нэгж болох Гэгээрэл төв үндсэн мэдээллүүдийг цуглуулж цаасаар болон word, excel-ийн файлаар аймагт, аймгаас АББЗСҮТ болон БСШУЯ-нд, харин тус хоёр байгууллага хэрэгцээт мэдээллээ харилцан солилцох байдлаар явагдаж байна (Зураг 3.1).



Зураг 4.1. Мэдээлэл дамжих үйл ажиллагааны загвар

“Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам” хэрэгжиж байгаатай уялдан БСШУЯ 2008-2009 оны хичээлийн жилээс АББ-ын үйл ажиллагаатай холбоотой захиргааны статистикийн дараах мэдээллийг авч байна:

- БДБ-7Б “АББ-ын Гэгээрлийн төвд ажиллагчид” маягтад ажиллагчдын тоо нас, хүйс, мэргэжлийн зэрэг, боловсролын түвшнээр
- БДБ-12 “Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлэг, суралцагчдын тоо” маягтад тоог боловсролын түвшин, нас, хүйсээр
- БДБ-15 маягтад ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тоо нас, хүйс, шалтгаанаар
- БДБ-20Б “Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг төгсөгчид” маягтад дүйцсэн хөтөлбөрийн, бичиг үсгийн, хүн амын боловсролын хэрэгцээг хангах сургалтыг төгсөгчдийн тоог нас, хүйсээр

ДХС-тай холбоотойгоор эдгээр мэдээллийг авч байгаа боловч салбарын статистикийн эмхэтгэлд БДБ-7Б, БДБ-20Б маягтуудаар авсан мэдээ тусгагдаагүй байгаа нь энэ чиглэлээр сонирхсон байгууллага, иргэд мэдээлэл авах боломжийг хааж байна.

3.2. ДҮЙЦСЭН СУРГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дээр дурдсан мэдээлэл дүйцсэн хөтөлбөрийн сургалт явуулах журмын хэрэгжилтэд хяналт тавихад хангалтгүй юм. Тиймээс АББ-ын нэгдсэн мэдээллийн сантай болох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 2009 оны сүүлээр боловсруулж дууссан програм хангамжид дээрхийг агуулсан дараах төрлийн багц мэдээллийг оруулав. Үүнд:

- АББ-ын Гэгээрэл төвийн:
 - Ажилтан
 - Сургалтын орчин
 - Сургалт
 - Суралцагч
 - Санхүүжилт
 - Төсөл, хөтөлбөр
 - Аж ахуйн нэгж, түүнээс зохион байгуулсан сургалт
 - Бичиг үсэг үл мэдэгч, сургууль завсардсан хүмүүсийн бүртгэл

Мэдээллийн сангийн програм хангамжийн дээр дурдсан талбар бүр ижил бүтэцтэй (Зураг 3.2).

Зураг 3.2. АББ-ын мэдээллийн сангийн програм хангамжийн үндсэн цонх

Түүнчлэн тоон мэдээ авахын зэрэгцээ Гэгээрэл төвийн сургалтын орчин, багшлах боловсон хүчин, дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдсан суралцагчид гэх мэтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн (Зураг 3.2, 3.3).

АББ-ын чиглэлээр зохион байгуулж буй сургалтууд, үүн дотроо дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг “Сургалт” талбарт бүртгэнэ (Зураг 3.2).

„—рб £ ""%—р"ы' ЪАйл—э' >jmj'£ jpiй' —р<a'ta'Љ >ий-Љ' γ u' su ' <ээ

Зураг 3.3. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын мэдээг оруулах дэд талбар

Жишээлбэл, сургалтад хамрагдсан хүмүүсийн мэдээллийг урьдчилан “Суралцагч” дэд талбарт бүртгэж, тухайн суралцагч бусад сургалтад хамрагдахад дахин бүртгүүлэх шаардлагагүй болох юм (Зураг 3.1, Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1. Суралцагчдыг бүртгэх үзүүлэлтүүд

Салбар нэгж	Овог	Нэр	Төрсөн огноо	Регистрийн №	Яс үндэс	Бүртгүүлсэн огноо	Хүйс	Үндсэн захиргаа	Малчны хүүхэд эсэх	Өнчин эсэх	Нэн ядуу эсэх	Бичиг үсгийн мэдлэг	Сургуульд орж байсан эсэх	Сургууль завсардсан эсэх	Завсардсан он	Завсардсан анги	Завсардсан шалтгаан	Хөгжлийн бэрхшээлтэй эсэх
-------------	------	-----	--------------	--------------	----------	-------------------	------	-----------------	--------------------	------------	---------------	---------------------	---------------------------	--------------------------	---------------	-----------------	---------------------	---------------------------

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Завсардсан шалтгаан гэсэн багананд “ажил эрхлэхээр, амьдралын гачигдлаас, өвчний улмаас, сурах дургүйгээс, шилжилт хөдөлгөөнөөс, бусад” зэргээс сонгож бичнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй эсэх гэсэн багананд “үгүй, бие эрхтний, оюун ухааны, сонсох эрхтний, хавсарсан хэлбэрийн, харах эрхтний, хэл ярианы” зэргээс сонгож бичнэ.
- Бичиг үсгийн мэдлэг гэсэн багананд “үл мэдэгч, бага мэдэгч, сайн мэдэгч” зэргээс сонгож бичнэ.
- Өнчин эсэх гэсэн багананд “өнчин биш, хагас өнчин, бүтэн өнчин” зэргээс сонгож бичнэ.

„—рб £ ”“”%о—р”“ы’ ЉАйл—э’ >jmj’£ jpiy’ —р<а’та’Љ >ий—АА’ у u’ su ‘ <ээ

АББ-ын мэдээллийн сангийн програм хангамжийн нэг давуу тал нь хэд хэдэн хэл ажиллах боломжтой. Жишээлбэл, суралцагчдын бүртгэлийн үзүүлэлтийг англи хэл дээр харж болно (Зураг 3.4).

Зураг 3.4. Суралцагчдыг бүртгэх талбар англи хэлээр

“Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-д зөвшөөрөл авсан хувь хүн, бусад байгууллага дүйцсэн хөтөлбөрийн сургалт явуулж болохыг заасан. Үүнийг харгалзан цаашдаа зөвхөн дүйцсэн хөтөлбөрийн сургалт гэлтгүй, ерөнхийдөө АББ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын мэдээг мэдээллийн санд бүртгэх, нэгтгэх зорилгоор тусгайд нь талбар нээсэн болно (Зураг 3.5).


Зураг 3.5. Аж ахуй нэгж, байгууллага, хувь хүний зохион байгуулсан сургалтыг бүртгэх талбар

Ингэснээр АББ-ын салбарт үйлчилгээ эрхэлж буй төрийн болон гадаад, дотоодын олон улсын болон ТББ-уудын үйл ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах болмжийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ.


3.3. МЭДЭЭЛИЙН САНГИЙН АШИГЛАЛТ, ТУЛГАРЧ БҮЙ АСУУДЛУУД

Одоогийн байдлаар мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийн үзүүлэлтүүдийг Гэгээрэл төвүүд рүү орон нутагт АББ хариуцсан мэргэжилтнээр дамжуулан илгээж, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа явагдаж байгаа, үүний дараа мэдээллийг аймаг, сум бүрээр санд бүртгэн оруулна (Зураг 3.6).

Өмнөх жилүүдэд аймаг, сумд интернетийн сүлжээгүй, богино хугацаанд харилцах боломж хязгаарлагдмал байсантай харьцуулахад олон сургууль интернетэд холбогдсон байгаа нь дэвшилттэй зүйл юм. Гэсэн хэдий ч нэгдсэн мэдээллийн сантай болж, онлайнаар түүнд хандан мэдээллээ оруулахад одоогийн интернетийн хурдны хүчин чадал хүрэлцэхгүй байгаа нь АББ-ын мэдээллийн санг зориулалтаар нь бүрэн ашиглахад хүндрэл учруулж байна.



Цаашид интернетийн хурдны асуудал шийдэгдвэл сум орон нутгаас ч АББ-ын багш, мэргэжилтнүүд мэдээллийн санд өөрсдөө хандан мэдээгээ оруулах боломж нээлттэй байгаа юм.




СУРГАЛТЫН АГУУЛГА, АРГА ЗҮҮН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

4.1. СУРГАЛТЫН АГУУЛГА

4.2. СУРГАЛТЫН АРГА ЗҮҮ

**4.3. СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫН НЭР ТӨРӨЛ,
ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ**



4.1. СУРГАЛТЫН АГУУЛГА

АББ-ын хөтөлбөрүүдийн дотроос агуулга, арга зүйн хувьд нэлээд боломжийн түвшинд хүрсэн нь дүйцсэн сургалтын хөтөлбөр юм. Дээр дурдсаны дагуу дүйцсэн сургалтын хөтөлбөрийг 2001 онд анх боловсруулж, хэдэн жил туршсаны үндсэн дээр Боловсролын шинэ стандарттай уялдуулан 2005 онд дахин шинэчлэн боловсруулж, хэрэглэж байна. Шинэчилсэн хөтөлбөр нь Боловсролын стандартад уялдсан, цогц чадамж төлөвшүүлэхэд чиглэсэн бөгөөд сурлцагчдын эзэмших мэдлэг, чадвар нь “харилцах”, “эрдэмших”, “амьдрах” ба “иргэнших” арга ухаан гэсэн 4 хэсэгтэй (Хүснэгт 4.1, 4.2, 4.3).

Хүснэгт 4.1. Дүйцсэн сургалтын хөтөлбөрийн агуулга

АГУУЛГА:

1. Оршил
2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн зорилго
3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн зорилт
4. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн агуулга
- 4.1. Эзэмших цогц чадамжийн шалгуур:
 - Харилцах арга ухаан
 - Эрдэмших арга ухаан
 - Амьдрах арга ухаан
 - Нийгэмших арга ухаан
- 4.2. Цогц чадамжийн хүрээнд эзэмших чадварууд:
 - Харилцааны чадварууд
 - Эрдэмших арга ухааны чадварууд
 - Амьдрах ухааны чадварууд
 - Нийгэмших арга ухааны чадварууд

Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн модулиуд

Хүснэгт 4.2. Цогц чадамжийн төлөвшилийн боловсролын түвшний үндсэн шалгуур (жишээ)

Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Харилцах арга ухаан		
Санаа бодлоо амаар, бичгээр, зураг дүрслэлээр болон үйл хөдлөлөөр чөлөөтэй илэрхийлж байгаа эсэх	Санаа бодлоо амаар, бичгээр, зураг дүрслэлээр болон үйл хөдлөлөөр чөлөөтэй, зөв, оновчтой, илэрхийлж байгаа байдал	Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ шинжлэх ухаанч байж асуудалд шүүмжлэлтэй хандан идэвхтэй, ухамсартай, хариуцлагатай байгаа эсэх
Эрдэмших арга ухаан		
Аливаа юмс, үзэгдэл, үйл явдал, нөхцөл байдлын шинж чанар, хувьсал, өөрчлөлт, төлөв байдлын ерөнхий болон гол шинж чанарыг ялган таньж байгаа эсэх	Аливаа юмс, үзэгдэл, үйл явдлын хувьсал, өөрчлөлтийн талаар таамаглал дэвшүүлэх, үнэний хувьтай шийдвэр гаргасан байдал	Аливаа юмс, үзэгдэл, үйл явдал, тэдгээрийн шинж чанар, хувьсал өөрчлөлт, харьцааг бодит тоон болон үйлдлийн чанарт үндэслэн тайлбарлаж чадах эсэх
Амьдрах арга ухаан		
Өөрийгөө таних, амьдрах арга ухааны талаар энгийн ойлголттой болсон байдал	Түгээмэл гүйцэтгэх ажил үүргийн болон мэргэжлийн чиг баримжаа олсон байдал	Тасралтгүй бие даан суралцах, аливаа ажил үүргийг зөв зохион байгуулж гүйцэтгэх байдал
Иргэнших арга ухаан		
Өөрийгөө танин мэдэх эрмэлзлэлтэй байгаа эсэх	Өөрийн үнэ цэнийг мэдрэх, өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэлтэй байх	Өөрийн үнэ цэнийг мэдрэх, өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэлтэй байгаа эсэх

Хүснэгт 4.3. Модулийн агуулга (жишээ);

Модулийн нэр	Зорилго	Агуулга	ББ	СБ	БДБ
Өсөхөөс сурсан үндэсний хэл	Эх, өгүүлбэрийн санаа, үг, бүтээврийн утгын хэв шинжийг таних, ялгах, тайлбарлах	Төрөл бүрийн сэдэвт эхийг уншаад гол утгыг ойлгох, эсрэг ба ойролцоо эх зохиох, эхийг зүйлчилсэн утгаар нь тодорхойлох, эхийн өнгө аяс, эхийн эхлэл, гол, төгсгөл, хэсгийг таних, тайлбарлах, өгүүлбэр, түүний гол санааг олох, үг, түүний хэв шинжүүдийг ялгах, бүтээвэр, түүний утгын хэв шинж, хэлц ба хэлц бус нэгжийн тухай	√	√	√

ДХС-ыг ийнхүү модуль сургалтаар зохион байгуулж буй нь суралцагчдын эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгаад одоогоор хяналт, үнэлгээ хийгдээгүй байна. Тиймээс цаашид модулийн агуулга, хэлбэр, хэмжээ, хүртээмж зэрэгт цогц үнэлгээ хийж, түүний мөрөөр арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй. АББЗСҮТ ДХС-ын модулиудад үнэлгээ хийх ажлыг 2010 оноос зохион байгуулахаар төлөвлөж байна.

Сургалтын үед хөтлөх бичиг баримтын хувьд “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ын 3.3-т “сургалтын явц, үр дүнг багшийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт хөтөлнө” гэж заагдсан.

Өнөөгийн байдлаар АББ-ын багш нар үйл ажиллагаандаа ЕБС-ийн багш нарын хэрэглэдэг журналыг ашиглаж байна. Хувийн хэргийн тухайд сургууль завсардсан цөөн хүмүүс дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдахдаа сургуульд сурч байхад нь нээсэн хувийн хэргээ авчирдаг тул түүнийг үргэлжлүүлэн хөтөлдөг байна. Харин үлдэх суралцагчдад шинэ хувийн хэргийг нээдэг ажээ.

Гэвч АББ-ын сургалт, үйл ажиллагааны онцлогтой уялдаад АББ-ын багшийн журнал, хувийн хэрэг байх нь зайлшгүй шаардлагатай болох нь багш, сургуулийн удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлагаас харагддаг. Түүнчлэн суралцагчийн ямар байдлаар үнэлэх, үнэлгээг хэрхэн баталгаажуулах гээд шийдвэрлэвэл зохих асуудал байсаар байна. Үүний эхний алхам болгож манай төвөөс АББ-ын үйл ажиллагаа, сургалтын онцлогт нийцүүлэн багшийн журнал, суралцагчийн хувийн хэргийн нэгэн хувилбарыг боловсруулсныг дор орууллаа. Энэхүү хувилбарыг дахин сайжруулж, БСШУЯ-наас зөвшөөрөл авч батлуулсны дараа ашиглах юм (Хавсралтыг үзнэ үү).

4.2. СУРГАЛТЫН АРГА ЗҮҮ

Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид нь нас, мэдлэгийн түвшин, амьдралын туршлага зэргээрээ ялгаатай учир жирийн сургуулиас өөр арга барил шаардлагатай байдаг. Иймд холимог бүлгийн арга зүйг ашиглаж байна. Холимог бүлгийн арга нь бусад улс оронд сургуулийн өмнөх болон бага оврын сургуульд өргөн ашиглагддаг боловч манайд албан бус боловсролын салбарт, тэр дундаа дүйцсэн хөтөлбөрийн сургалтад нэлээд өргөн хүрээтэй нэвтрээд байна.

Энэхүү арга зүйг сургалтад нэвтрүүлэхийн тулд багш нарт зориулсан хэд хэдэн гарын авлага гарсан бөгөөд холимог бүлгийн сургалтын аргазүй, хөтөлбөр боловсруулан хэрэглэж байна. Одоогоор ажиллаж буй АББ-ын багш нарын 60 орчим хувь нь холимог бүлгийн аргазүйн сургалтад хамрагдаж гэрчилгээ авчээ.

Дээр дурдсан сургалтыг АББЗСҮТ хөтөлбөр, төслүүдийн хүрээнд богино хугацаа (2-3 хоног)-гаар зохион байгуулдаг бөгөөд багшийг холимог бүлгийн сургалтын чиглэлээр системтэй бэлтгэх тогтолцоо төлөвшөөгүй байна. Нөгөө талаар багшийн нийгмийн халамжийн асуудал бүрэн шийдэгдээгүй, олон нийтийн АББ-ын талаар үзэл ойлголт хангалтгүй байгаа зэрэг олон хүчин зүйлээс хамааран АББ-ын Гэгээрлийн төвийн багш нар тогтвор суурьшилгүй ажилладаг нь багш бэлтгэлд шууд сөргөөр нөлөөлж байна. Хөтөлбөр төслийн хүрээнд жил бүр сургалт зохион байгуулдаг ч багш олноор солигддог, сургалт системтэй явагддаггүйгээс багш нарт арга зүйн бэлтгэлийг хангахад хүндрэлтэй байгаа тул цаашид төрөөс энэ чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай.


4.3. СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫН НЭР ТӨРӨЛ, ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

Өмнө дурьдсан хөтөлбөрийн агуулгын хүрээнд боловсруулсан сургалтын хэрэглэгдэхүүн нэлээд хэд хэдэн төрөл байна. Тухайлбал, 2001 оны хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн бага боловсролын “Математик” ба “Монгол хэл” сурах бичиг НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэд хэдэн удаа хэвлэгдсэнээс гадна Математик нь казак хэл дээр орчуулагдан 1000 ширхэг түгээгджээ. Мөн суурь боловсролын математик-мэдээлэл зүй, монгол хэл-уран зохиол, байгалийн ухаан, англи хэл, орос хэл, нийгмийн ухаан, зураг хөдөлмөр зэрэг долоон багц сурах бичиг ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр анх 2001 онд боловсруулагдан туршигдаж, дахин сайжруулсаны үр дүнд 2004 онд тус бүр 8000 орчим хувь хэвлэгдсэн нь Гэгээрлийн төвд дунджаар 15-20 ширхэг хуваарилагдсан ба одоо хүртэл дүйцсэн хөтөлбөрийн сургалтын гол хэрэглэгдэхүүн болсоор байна. Суурь боловсролын энэ сурах бичгээс “Математик-мэдээлэл зүй”, “Байгалийн ухаан”, “Нийгмийн ухаан” гурав нь мөн казак хэл дээр орчуулагдсан болно.

Харин 2005 оны шинэчилсэн хөтөлбөр нь 4 цогц чадамжид суурилсан модулан бүтэцтэйгээр, боловсролын түвшин тус бүрд суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар бүхий агуулгатай бөгөөд үүний дагуу бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын 200 гаруй модуль боловсруулахаар байгаа билээ. 2010 оны 3 дугаар сарын байдлаар нийтдээ 112 модуль боловсруулагдан гараад байгаагийн 46 нь бага, 45 нь суурь, 23 нь бүрэн дунд боловсролын түвшинд хамаарагдаж байна. Дээр дурдсан сурах бичгүүдтэй харьцуулахад эдгээр модулиуд цөөн тоогоор (голчлон тус бүр 500 ширхэг) хэвлэгдэн түгээгдэж байгаа нь суралцагч нэг бүрт хүртээмжгүй байгаа юм. Иймд хүссэн суралцагч хэрэгцээт модулиа хэвлэн авч хэрэглэхэд зориулан 2009 онд СД хэлбэрт шилжүүлээд байна (Зураг 4.4). Түүнчлэн одоогоор гараад буй бүх модулийг АББЗСҮТ-ийн цахим хуудаснаас авч болох аж.

„—рб £ ”“%—р”ы’ ЪАйль—э’ >jm’£ jрий’ —р<a’ta’Ъ >ий-Ъ’ γ u’ su’ ‘<э


Зураг 4.4. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын модулийн СД-дотоод бүтэц



Хэдийгээр АББ-ын Гэгээрлийн төвүүд сургалтын орчин үеийн тоног төхөөрөмжгүй ч бие даасан төвүүдийн хувьд энэхүү электрон сургалтын материалыг ашиглах боломжтой.


Одоогоор бага, суурь ба бүрэн дунд боловсролын “цөм” модулиуд бараг үндсэндээ бэлэн болсон бөгөөд дутуу байгаа амьдрах ухааны цогц чадамжид хамаарах мэдлэг чадварыг эзэмшиж болох бусад гарын авлага материалууд ч нэлээд гарчээ. Тухайлбал, амьдрах ухааны 7 гарын авлага, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр зэргийг дүйцсэн сургалтад ашиглах боломжтой.

Дээр дурдсан сургалтын материалаас гадна ЕБС-ийн сурах бичгүүд АББ-ын бусад хөтөлбөрүүд болох эрүүл мэндийн, экологийн болон бичиг үсгийн дараах амьдрах ухааны ном гарын авлагыг ч ашиглах боломжтой юм.



СУРГАЛТЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

- 5.1. ДҮҮЦСЭН ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАГЧ**
- 5.2. СУРГАЛТЫН ОРЧИН**
- 5.3. ЭЦЭГ ЭХ, ОРОН НУТГУЙН ДЭМЖЛЭГ**
- 5.4. СУРГАЛТЫН ҮР ДҮН, ТӨГСӨГЧИД**




5.1. ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАГЧ

Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд сургуульд огт ороогүй эсвэл завсардсан сургуулийн насны хүүхдээс гадна тухайн насандаа зохих шатны боловсрол эзэмшиж чадаагүй насанд хүрэгчид хамрагддаг. Одоогоор хүн амын бүлгийн хувьд харилцан адилгүй насны хүмүүс уг сургалтанд хамрагдаж буй боловч дийлэнх нь сургуулийн насны хүүхдүүд байна.

Суурь боловсролын ДХС-д хамрагддаг суралцагчдын нас, хүйс, суралцаж буй түвшин зэргийг үзүүлэлт болгон, сүүлийн гурван хичээлийн жилийн мэдээллийг авч үзье.


Зураг 5.1. 2006-2007 оны хичээлийн жилд ДХС-д хамрагдсан суралцагчдын тоо



2006-2007 оны хичээлийн жилд 8229 хүн бага, суурь боловсролын ДХС-д хамрагдсаны 84% нь сургуулийн насны хүүхэд байгаа бөгөөд 63% нь эрэгтэй, 37% нь эмэгтэй. Эдгээр хүүхдийн 63.4% нь бага, 36.6% нь суурь боловсролын ДХС-д хамрагджээ (Хүснэгт 5.1, Зураг 6.1).

Хүснэгт 5.1

Нас	2006-2007 оны хич.жилд ДХС-д хамрагдагчид			Үүнээс:					
				Бага боловсрол			Суурь боловсрол		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Сур.насны хүүхэд	6913	4366	2547	4385	2713	1672	2528	1609	925
7-10 настай	594	341	253	533	312	221	61	29	32
11-15 настай	3843	2410	1433	2819	1751	1068	1024	659	365
16-18 настай	2476	1615	861	1033	650	383	1443	915	528
Насанд хүрэгчид	1316	796	520	555	372	183	761	474	287
19-24 настай	1096	672	424	465	282	183	631	390	287
25-аас дээш настай	220	124	96	90	90	0	130	84	46
Бүгд	8229	5162	3067	4940	3085	1855	3289	2077	1212




Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл

Тус хичээлийн жилд ДХС-д хамрагдсан сургуулийн насны хүүхдийн 55%-ийг 11-15, 36%-ийг 16-18, 9%-ийг 7-10 насныхан тус тус эзэлж байна (Зураг 5.2).

Үүнээс бага боловсролын ДХС-д хамрагдаж буй суралцагчдын 64% нь 11-15, 24% нь 16-18, 12% нь 7-10 насныхан тус тус байгаа бол суурь боловсролын сургалтанд хамрагдагчдын 57% нь 16-18, 41% нь 11-15 насныхан байна (Зураг 5.3).

Зураг 5.3. Бага, суурь боловсролын түвшний сургуулийн насны суралцагчид



5.3 дахь зургаас үзэхэд, 11-15 насныхан бага боловсролын ДХС-д түлхүү хамрагдаж байсан бол 16-18 насныхан суурь боловсролын сургалтанд өргөн хамрагдсан байна. Суралцагчдын насны байдлаас 16-18 насныхны 24% нь бага боловсролын ДХС-д хамрагдаж буй нь холимог нас, түвшний бүлгийг бүрдүүлж байгааг харж болно.

2007-2008 оны хичээлийн жилд бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтанд 10069 хүн хамрагдсан байна (Хүснэгт 5.2).


Хүснэгт 5.2. 2007-2008 оны хич.жилд ДХС-д хамрагдагчид

ДХ-өөр суралцагчдын нас	Бүгд	Эр	Эм
Сургуулийн насны хүүхэд (10-18 нас)	7946	5027	2919
10 хүртэлх настай	561	320	241
11 настай	461	267	194
12 настай	654	394	260
13 настай	794	513	281
14 настай	1062	662	400
15 настай	1242	833	409
16 настай	1375	901	474
17 настай	1048	670	378
18 настай	749	467	282
Насанд хүрэгчид (19-ээс дээш нас)	2123	1349	774
Бүгд	10069	6376	3693


Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл

Нийт хамрагдсан хүний 63% нь эрэгтэй, 37% нь эмэгтэй (Зураг 5.4, 5.5).

Зураг 5.4. ДХС-д хамрагдсан суралцагчдын хүйс




Зураг 5.5. ДХС-д хамрагдах нас




Тус хичээлийн жилд ДХС-д хамрагдсан суралцагчдын насны байдлыг авч үзвэл, 79% нь сургуулийн насны хүүхэд байна (Зураг 5.6). Энэ нь сургууль завсардсан болон огт ороогүй сургуулийн насны хүүхдүүд ДХС-д өргөнөөр хамрагдаж буйн нотолгоо юм.

Зураг 5.6. ДХС-д хамрагдагчдын нас



Зураг 5.10. ДХС-д хамрагдсан хүүхдийн насны эзлэх хувь



ДХС-д хамрагдсан сургуулийн насны хүүхдүүдийн насны байдлыг авч үзвэл 16-18 насныхан 40%, 13-15 насныхан 39%-ийг тус тус эзэлж байна (Зураг 5.7). Үүнээс 13-18 насныхан ДХС-д түлхүү хамрагдсан нь харагдаж байна. Ялангуяа уг сургалтанд хамрагдсан сургуулийн насны хүүхдийн дийлэнхийг 15,16 настай суралцагчид бүрдүүлж байна.


2008-2009 оны хичээлийн жилд нийт 12319 хүн бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтанд хамрагдсанаас 63,9% нь эрэгтэй, 36,1% нь эмэгтэй байна. 50.6% нь бага, 40.4% нь суурь боловсролын ДХС-д тус тус хамрагджээ (Хүснэгт 5.3).

Хүснэгт 5.3. 2008-2009 оны хич.жилд ДХС-д хамрагдагчид

Үзүүлэлт	Бүгд	Эр	Эм	Үүнээс:								
				Бага боловсролд хамрагдагчид			Суурь боловсролд хамрагдагчид			Үүнээс: Төгсөх ангид суралцагчдын тоо		
				Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
ДС-нд хамрагдагчдын тоо	12319	7880	4439	6241	3998	2243	4982	3223	1759	1997	1259	738
Үүнээс сургуулийн насны хүүхдийн тоо	9212	5932	3280	5348	3438	1910	3587	2313	1247	1328	836	492
9 настай	417	245	172	389	224	165	28	21	7	0	0	0
10 настай	306	187	119	293	180	113	13	7	6	0	0	0
11 настай	522	313	209	480	288	192	42	25	17	0	0	0
12 настай	742	467	275	664	415	249	78	52	26	0	0	0
13 настай	984	631	353	802	520	282	181	110	71	10	6	4
14 настай	1190	777	413	804	517	287	386	260	126	32	24	8
15 настай	1365	870	495	696	453	243	664	413	251	208	118	90
16 настай	1420	932	488	533	365	168	860	545	315	409	248	161
17 настай	1279	861	418	399	278	121	790	521	269	391	253	138
18 настай	987	649	338	288	198	90	545	359	186	278	187	91
19-24 настай	2316	1487	829	893	691	202	1117	736	381	517	327	190
24< настай	791	461	330	608	477	131	278	174	104	152	96	56

Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл


Зураг 5.8. ДХС-д хамрагдсан




Тухайн жилд ДХС-д нийт 6580 хүн шинээр хамрагдсаны 15% нь сургуульд огт ороогүй, 39% нь сургууль завсардсан хүүхдүүд байжээ. Харин 46% нь сургалтанд үргэлжлүүлэн хамрагдаж буй суралцагчид аж (Зураг 5.8).

Зураг 5.9. ДХС-д хамрагдагчид

ДХС-д хамрагдаж буй суралцагчдын 75% нь сургуулийн насны хүүхэд байна (Зураг 5.9). Үүнээс сургуульд огт ороогүй, эсвэл завсардсан хүүхдүүдийн хамрагдалт сайн байгаа бөгөөд ДХС-ийн хүртээмж нэмэгдэж байна гэж үзэж болно.




Зураг 5.10. ДХС-д хамрагдсан хүүхдийн насны эзлэх хувь



ДХС-д хамрагдсан хүүхдүүдийн насны байдлыг дэлгэрүүлэн авч үзье. Нийт хамрагдсан сургуулийн насны хүүхдийн дийлэнхийг 13-аас дээш насныхан бүрдүүлж байна. 15-16 насныхан тус тус 15%, 17 насныхан 14%, 14 насныхан 13%, 13 болон 18 насныхан тус бүр 11%-ийг эзэлж байна (Зураг 5.10).

Зураг 5.11. Бага боловсролын ДХС-д хамрагдсан сургуулийн насны хүүхэд

Эдгээр сургуулийн насны хүүхдийн 58% нь бага, 38,9% нь суурь боловсролын ДХС-д тус тус хамрагджээ (Зураг 5.11). Суурь боловсролын сургалтанд хамрагдаж буй сургуулийн насны хүүхдийн 37% нь төгсөх ангид суралцаж байна.



Тус хичээлийн жилд хамрагдсан нийт суралцагчдын 53.5% нь малчны хүүхэд байгаа нь хөдөө мал маллах зорилгоор хүүхдүүд ихээр сургууль завсарддаг, эсвэл огт ордоггүйн баталгаа болж байна.

Гэхдээ энд малчны хүүхэд гэдэг нэрээр айлын мал маллаж өрхийн орлогодоо тодорхой нэмэр оруулдаг хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байгааг энд зориуд онцлох хэрэгтэй. Түүнчлэн нийт суралцагчдын 1.2% нь бүтэн өнчин, 9.7% нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

ДХС-д хамрагдаж буй суралцагчдын тоо сүүлийн гурван жилд тасралтгүй нэмэгдэж байна (Хүснэгт 5.5).

Хүснэгт 5.5. ДХС-д хамрагдагчид

№	Хичээлийн жил	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагдагчид			Үүнээс: Сургуулийн насны хүүхэд		
		Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
1	2006-2007 он	8 229	5 162	3 067	6913	4366	2547
2	2007-2008 он	10 069	6 376	3 693	7946	5027	2919
3	2008-2009 он	12 336	7 888	4 448	9205	5926	3279

Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл

Хүснэгтээс үзвэл, суралцагчдын тоо хичээлийн жил бүрт ойролцоогоор 2000-аар нэмэгдсэн нь хувьсах зардал олгодог болсноор сургалтын хүртээмж дээшилсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Нийт суралцагчдын ойролцоогоор 63.3%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь 1990-ээд оны нийгэм, эдийн засгийн шилжилтийн үед ажил хөдөлмөр эрхэлж гэр орныхондоо туслах зорилгоор хөвгүүд олноор завсардсантай холбоотойгоор эрэгтэйчүүдийн хамрагдалт их байгааг тайлбарлаж болно.

2007-2008, 2008-2009 оны хичээлийн жилд ДХС-д хамрагдсан суралцагчдыг хот, хөдөөгөөр ялган авч үзье (Хүснэгт 5.6).

2007-2008 оны хичээлийн жилд сургуулийн насны 7946 хүүхэд ДХС-д хамрагдсанаас хөдөөд 81.4%, хотод 18.6% нь тус тус ногдож байна.

Хүснэгт 5.6. ДХС-д хамрагдагчид, хот, хөдөөгөөр


ДХС-д хамрагдсан хүүхэд	Хөдөөд						Хотод*					
	2007-2008			2008-2009			2007-2008			2008-2009		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
<10	384	229	155	578	345	233	177	91	86	133	77	56
11	361	223	138	397	241	156	100	44	56	125	72	53
12	501	315	186	620	397	223	153	79	74	122	70	52
13	633	422	211	820	525	295	161	91	70	164	106	58
14	897	580	317	1008	676	332	165	82	83	182	101	81
15	1067	746	321	1180	764	416	175	87	88	187	106	81
16	1097	738	359	1239	826	413	278	163	115	180	107	73
17	892	592	300	1106	762	344	156	78	78	173	98	75
18	643	422	221	899	608	291	106	45	61	92	44	48
Нийт	6475	4267	2208	7847	5144	2703	1471	760	711	1358	781	577

Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл


* Хотод Дархан-Уул, Орхон, Улаанбаатар багтсан.

Тус хичээлийн жилд хөдөөд ДХС-д хамрагдсан 6475 суралцагчийн дийлэнх буюу 65.8% нь эрэгтэй байгаа бол хотод эрэгтэй, эмэгтэй суралцагчийн тоо харьцангуй тэнцвэртэй байна (Зураг 5.12).

Зураг 5.12. 2007-2008 онд ДХС-д хамрагдсан хүүхэд, хот, хөдөөгөөр




Зураг 5.13. 2008-2009 онд ДХС-д хамрагдсан хүүхэд, хот, хөдөөгөөр




2008-2009 оны хичээлийн жилд ДХС-д 9205 сургуулийн насны хүүхэд хамрагдсанаас 85.2% хөдөөд, 14.8% хотод тус тус ногдож байна. Хөдөөд сургалтанд хамрагдагчдын 65.5% нь эрэгтэй, хотод 57.5% нь эрэгтэй байна (Зураг 5.13).

ДХС-д хамрагдагсдын тоог дээр хоёр хичээлийн жилээр авч үзвэл, хөдөөд эхний жилээс сүүлийн жилд 1300 орчим суралцагчаар нэмэгдсэн байгаа бол хотод 100 орчим хүүхдээр буурсан үзүүлэлттэй байна (Зураг 6.14, 6.15).

Зураг 5.14. ДХС-д хамрагдсан хүүхэд хөдөөд



Зураг 5.15. ДХС-д хамрагдсан хүүхэд хотод



Эдгээрээс дүгнэж үзвэл, сургуулийн гадна байгаа болон завсардсан хүүхдийн дийлэнх нь эрэгтэй, ялангуяа хөдөөд мал малладаг хүүхдүүд ДХС-д хамрагдаж байгаа нь эндээс харагдаж байна.

Сургуулийн гадна буй хүүхдийн хичнээн хувь нь ДХС-д хамрагдаж буй талаар авч үзье. Сургууль завсардсан, сургуулийн гадна хэчнээн хүүхэд байгаа талаар үнэн бодитой мэдээлэл байдаггүй нь ДХС-ын үр дүнг үнэлэх, цаашдын үйл ажиллагааг төлөвлөхөд бэрхшээл учруулж байна. Тухайлбал, ОУХБ-аас хийсэн “Монголын хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал” ³судалгаанд сургуулийн гадна 29556, казак хүүхдийн боловсролын судалгаанд хийсэн тайланд⁴ 36 мянга орчим хүүхэд байна гэсэн харилцан адилгүй мэдээлэл байна. АББЗСҮТ-ийн мэдээгээр 2005 онд 41 716, 2006 онд 22 198 хүүхэд сургуулийн гадна байна гэжээ. БСШУЯ-наас “БДБ-15: Сургуулийн гадна буй 6-14 насны хүүхэд” гэсэн үзүүлэлтээр ЕБС-иас авдаг нь мэдээллийн эх сурвалжаа олоогүй, үнэн бодит байх боломжийг хангаагүй гэж үзэж байна.

³ Монголын хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, УБ., 2008

⁴ Казак хүүхдийн боловсролын судалгааны тайлан. УБ., 2008

Албан ёсны захиргааны маягтаар авдаг гэдэг утгаар нь БСШУЯ-ны мэдээлэлд үндэслэн сургуулийн гадна байсан хэчнээн хүүхэд ДХС-д хамрагддагийг авч үзье. 2007-2008 оны онд 8-15 насны нийт 8775 хүүхэд сургуулийн гадна байсан бол 2008-2009 оны хичээлийн жилд шинээр 3361 хүүхэд ДХС-д хамрагджээ (Хүснэгт 5.7).

Хүснэгт 5.7

Үзүүлэлт	Сургуулийн гадна буй хүүхдийн тоо (2007-2008 оны хич.жил)			ДХС-д шинээр хамрагдсан хүүхдийн тоо (2008-2009 оны хич.жил)		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
8-11 нас	3418	1807	1611	888	589	299
12-15 нас	5357	3385	1972	2473	1589	884
Нийт	8775	5192	3583	3361	2178	1183

Эх сурвалж: БСШУЯ-ны Статистикийн эмхэтгэл

Сургуулийн гадна буй нийт хүүхдийн тоонд 8-11 насныхны эзлэх хувь 38.9, 12-15 насныхны эзлэх хувь 61.1 байна. 8-11 насны сургуулийн гадна буй хүүхдийн 25,9% нь, 12-15 насныхны 46.1% нь тус тус ДХС-д хамрагдсан байна. Энэ нь нийт сургуулийн гадна буй хүүхдийн **38.3%** нь ДХС-д хамрагдсан гэсэн үг юм.

ДХС үндэсний цөөнхөд ялангуяа казак хүүхдэд хэр хүртээмжтэй байгаа талаар авч үзье. 2007-2008 оны хичээлийн жилийн байдлаар сургуулийн гадна буй 7-15 насны 8775 хүүхэд байгаагийн 27.6%-ийг дангаараа Баян-Өлгий аймаг бүрдүүлж байна. Тус хичээлийн жилд сургуулийн насны 79 хүүхэд ДХС-д хамрагджээ. Энэ нь хөдөөд хамрагдсан нийт хүүхдийн дөнгөж 1.2%-ийг бүрдүүлж байна. 2008-2009 онд ДХС-д хамрагдагчдын тоо даруй 450 орчим хүүхдээр нэмэгдсэн байгаа нь хүртээмж дээшилснийг илтгэж байна. Энэ нь хөдөөд сургалтанд хамрагдсан хүүхдийн 6.7%-ийг эзэлж байна⁵. Сургуулийн гадна байгаа хүүхдийн тоогоор бусад аймагтай харьцуулахад өндөр ч ДХС-ын хамрагдалт харьцангуй бага байгаа нь дээрх тоон үзүүлэлтүүдээс харагдаж байна.

Дээрхээс дүгнэхэд, суралцагчдын хамрагдалт хангалтгүй түвшинд байгааг сургуулийн гадна байгаа болон завсардсан хүүхдүүд төрийн бодлогын гадна үлдэж байгаатай холбон авч үзэх болох юм. Юун түрүүнд ДХС-д хамрагдаж буй хүүхдүүд дотуур байрны үйлчилгээнд хамрагдахгүй байна. Энэ талаар нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүйгээс дотуур байраар хангах эсэх нь сургуулийн удирдлагын үзэмж, ойлголтоор шийдвэрлэгддэг болжээ. Сумын төвд байх айлгүй шалтгаанаар сургалтанд хамрагдахгүй байх, дутуу орхиж явах нь газар дээрээ өдөр тутмын үзэгдэл болоод байна. Түүнчлэн ДХС-д хамрагдаж буй хүүхдүүд “Үдийн цай” хөтөлбөрийн гадна үлдэж байна. Тэдгээр хүүхдийн дийлэнх нь бага орлоготой өрхийн гишүүд байдаг тул уг хөтөлбөрт хамруулах нь сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх нэг үндэс болно.

Суралцагчдын талаарх дээр дурдсан дүн шинжилгээг БСШУЯ-ны статистикийн мэдээлэлд үндэслэн хийсэн болно. Учир нь БСШУЯ болон АББЗСҮТ-д ирүүлсэн мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байгаа нь дүн шинжилгээ хийхэд бэрхшээл учруулж байна.

⁵ БСШУЯ-ны статистикийн эмхэтгэл

Тухайлбал 2006-2007 оны хичээлийн жилд 443, 2007-2008 онд 329, 2008-2009 онд 177 суралцагчийн тоогоор зөрүүтэй мэдээлэл хоёр байгууллагад иржээ (Хүснэгт 5.8).

Хүснэгт 5.8

№	Хичээлийн жил	БСШУЯ			АББЗСҮТ	Зөрүү
		Бүгд	Эр	Эм	Бүгд	
1	2006-2007 он	8229	5162	3067	8672	443
2	2007-2008 он	10069	6376	3693	10398	329
3	2008-2009 он	12319	7880	4439	12496	177

Энэ нь ДХС-ийн үр дүнг үнэлэх, уг сургалтыг цаашид эрчимжүүлэхэд авах арга хэмжээг тодорхойлох боломжийг сааруулж, улмаар хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бүрдүүлэх зорилтыг хангахад саад болж байгаа юм. Тиймээс бодитой мэдээллийг нэгдсэн арга замаар цуглуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд АББ-ын мэдээллийн электрон сангийн програм боловсруулаад байгааг өмнөх бүлэгт дурьдсан болно.


5.2. СУРГАЛТЫН ОРЧИН

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын орчинд АББ-ын Гэгээрэл төвийн байр, анги танхим, анги дүүргэлт, багш, суралцагчийн харьцаа, ном, сурах бичгийн хүрэлцээ хангамж, сургалтын киррикулум, стандарт, АББ-ын үйлчилгээнд гаднах орчны үзүүлж буй дэмжлэг, нөлөөллийг авч үзэж байна.

Зураг 5.16. Гэгээрлийн төвийн сургалтын байр

Лэз-ы' Мэсээр'уй' тј%оуй'“амЬруа““а<

£ааз: АББ-ын Гэгээрэл төвүүд нь байр танхимын хувьд нийт Гэгээрлийн төвийн 97.2 хувь нь харъяа байгууллагын зөвхөн нэг өрөөнд үйл ажиллагаа, сургалтаа зохион байгуулдаг байна. Сургалтын танхим нь дунджаар 10-20 хүний багтаамжтай. 7 Гэгээрэл төв буюу 2 хувь нь 2-5 сургалтын өрөөтэй, харин 0.8 хувийг эзлэх 3 Гэгээрлийн төв (УБ хотын Баянгол дүүрэг, Дорнод аймгийн Чойбалсан сум, Орхон аймгийн Гэгээрэл төвүүд) 6-10 өрөөтэй, сургалт явуулах боломжоор харьцангуй сайн хангагдсан байна (Зураг 5. 16). Үүнээс үзвэл АББ-ын Гэгээрлийн төвүүд нь олон төрлийн сургалтыг зэрэг явуулах боломжгүйн дээр тэдгээрийн 60 гаруй хувь нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ширээ сандал нь хүрэлцээгүй, стандартын бус, суралцагчийн бие, насанд тохиороогүй байна.



Мөн сургуулийн коридорт хаалт хийн сургалтын өрөө байгуулсан, нурж буй байшин, галлагаа муу, хүйтэн өрөөнд байрладаг Гэгээрэл төвүүд ч байна. Сургалтын танхимын багтаамжийн хувьд дунджаар 20 хүний хүчин чадалтай байгаа нь сумдын Гэгээрэл төвүүдийн хувьд боломжийн байгаа ч хүн ам ихтэй суурин газарт анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Түүнчлэн Гэгээрлийн төвүүдийн 93 хувь нь компьютергүй, 98 хувь нь олшруулагчгүй, 98.5 хувь нь дэлгэцийн төхөөрөмжгүй, 99.4 хувь нь видео төхөөрөмжгүй, 89.2 хувь нь аудио төхөөрөмжгүй, мөн багш нарын компьютер хэрэглээний мэдлэг дутмаг, сургалтын материал бэлтгэх санхүүжилт байхгүйгээс бүх төвүүдэд жигд бэлтгэж чадахгүй байна.

загү, ——ра’ла<Ций’арьяа: Нэг багшид ноогдох суралцагчдын хувьд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах журмын дагуу танхимын сургалтын үед бүлгийг 15-аас, гэрийн буюу шавь сургалтын үед 10-аас дээш суралцагчтайгаар явуулах ёстой. Нэг бүлэгт ноогдох суралцагчдын тоо дунджаар хөдөө орон нутагт 15-20, суурин газарт 20-25 байгаа нь ЕБС (нэг бүлэгт ойролцоогоор 35 сурагч)-тай харьцуулбал АББ-ын Гэгээрлийн төвийн багшийн ажлын ачаалал харьцангуй хялбар мэт санагдаж болох юм. Гэвч боловсролын түвшин, нас, сэтгэхүйгээрээ харилцан адилгүй холимог бүлэг бүрддэг тул багшаас өвөрмөц аргазүй, суралцагч бүрт тохирсон арга барил шаарддаг. Энэ талаас нь авч үзвэл, АББ-ын ГТ-ийн багш ЕБС-ийн багшаас харьцангуй хүнд ачаа үүрдэг байна.

„—р<а’ты’ “амЬруа’: Бага, дунд боловсролын түвшин бүрээр судлах модуль болон бусад кирриклюимын хүрээнд боловсруулсан гарын авлага, сурах бичиг мөн ЕБС-ийн сурах бичгийг давхар ашиглаж байна. Одоогоор бага, суурь боловсролын 190 гаруй модуль, гарын авлага боловсруулахаар төлөвлөснөөс 102 модулийг боловсруулж, 84 модулийг хэвлэжээ. Боловсруулсан модуль тус бүрийг 500 ширхэг хэвлэн бүх төвүүддээ тараахад нэг төвд дунджаар 1-2 модуль ногдож байгаа бөгөөд үүнийг суралцагчдын тоонд харьцуулбал 1 сурах бичигт ногдох суралцагчдын тоо 15-25 байна. Харин бусад сургалтын кирриклюимын хувьд хэдийгээр кирриклюим бүрт дагалдах сурах бичиг, гарын авлагыг боловсруулахыг зорьж байгаа ч хангалттай хэмжээнд хүрээгүй байна. Одоогоор 30 төрлийн гарын авлагыг тус бүрийг 1000 хувиар хэвлэн тараасан нь нэг төвд 2-3 ширхэг ноогдож байгаа ба нэг гарын авлагад ноогдох суралцагчдын тоо 7-13 байна.

Сургалтын материалын хүрэлцээ хангамж АББ-ын нийт Гэгээрлийн төвийн хэмжээнд ийнхүү дутагдалтай байгаагаас гадна үндэсний цөөнхөд зориулсан сургалтын материал, сурах бичгийн асуудал бас л шийдвэрлэх асуудал болон хувирч байна. АББЗСҮТ-өөс төсөл хөтөлбөрийн хүрээнд бага боловсролын “Математик”, суурь боловсролын “Нийгмийн ухаан”, “Байгалийн ухаан” зэрэг сурах бичгийг тус 1000 хувь хэвлэн түгээсэн. Түүнчлэн 2010 онд бага боловсролын ДХС-ын 20 цөм модулийг казак хэл рүү орчуулан хэвлэж түгээхээр ажиллаж байна.

загү £””%—”’>АЦи’: Өнөөдөр улсын хэмжээнд 458 АББ-ын багш ажиллаж байгаагийн 130 нь буюу 28.4 хувь нь бие даан үйл ажиллагаа явуулдаг 10 Гэгээрлийн төвд сургалтаа явуулж байгаа⁶ бөгөөд бусад Гэгээрлийн төвд АББ-ын нэг багш ноогдож байгаагаас үзэхэд эдгээр төвүүдийн үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадал хангалтгүй нь ойлгомжтой. Харин бие даасан 10 Гэгээрлийн төвд насанд хүрэгчдэд зориулсан сургалтууд бүрэн хэмжээнд явагдаж чадаагүй ч хүүхэд, өсвөр насныханд зориулсан сургалтууд тогтмол, үр дүнтэй явагдаж байна.

⁶ “Албан бус боловсролын багшийн мэдээ”, “Тушаалуудын танилцуулга” 2008

Мэдлэг, боловсролын тухайд, АББ-ын багш нарын 301 нь буюу 65.7 хувь нь дээд боловсролтой 157 буюу 34.3 хувь нь тусгай дунд боловсролтой байна. Цаашилбал, ЕБС-ийн бага боловсролын хүрээнд ихэвчлэн Багшийн коллеж төгссөн тусгай дунд боловсролтой багш нар хичээл заадаг бол АББ-ын хүрээнд зохион байгуулагдаж байгаа бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг дээд сургууль төгссөн багш нар заадаг, Гэгээрлийн төвүүдэд ажиллаж буй багш нарын 90.6 хувь нь багшийн мэргэжилтэй, зөвхөн 9.4 хувь нь өөр мэргэжлийн хүмүүс байгаа зэрэг нь багшлах боловсон хүчний боловсролын түвшин өндөр байгааг харуулж байна.

Гэвч АББ-ын багш нарын ажиллах нөхцөл (орчин, материаллаг бааз, унаа г.м.) сайнгүй, тэдэнд үзүүлэх нийгмийн халамж, шагнал урамшуулалын асуудал орхигддог, удирдлага, олон нийтийн туслалцаа сул зэрэг нь тогтвор суурьшилтай ажиллахад сөргөөр нөлөөлж байна. Улсын хэмжээнд ажиллаж буй багш нарын зөвхөн 163 нь буюу 35 хувь нь 3-аас дээш жил энэ салбарт ажиллаж байгаа⁷, түүнчлэн 1998-2004 онуудад АББЗСҮТ-өөс үндэсний түвшинд АББ-ын багшаар бэлтгэсэн нийт 1529 багшийн 20 хүрэхгүй шахам хувь нь өнөөдрийн байдлаар энэ ажлыг хашиж байгаа тоо баримт үүнийг нотолж байна.

Түүнчлэн ДХС-аар бага, суурь боловсрол нөхөн олгоход ЕБС-ийн багш нарын үүрэг ихээхэн чухал билээ. Тэдгээр багш нарын хувьд дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй хүүхдүүдийн амьдралын боломж, сурах нөхцлийг ойлгон хандаж сургахад анхаарч байгаа нь сайшаалтай байна.

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагддаг хүүхдүүдэд өнгөрсөн хичээлийн жилд математик заасан. Хүүхдүүд ч идэвхтэй сайн байсан. Анхны удаа самбар дээр тоо бичээд үүнийг хэн бодохов гэхэд араас нэг “охин” би бодъя гэсэн. Тэр охин жирэмсэн байсан. Сургалт гэдгийг сургуулийн хүүхдээр төсөөлдөг байсан надад энэ нь тун сонин санагдсан. Түүнээс хойш сургалтанд хамрагдаж буй янз бүрийн насны хүмүүсийг ойлгож, мэддэг болсон.

Увс аймгийн Баруунтуруун сумын хичээлийн эрхлэгч н.Мандахын ярианаас... (2010, 3 сар)

Тиймээс багш нарт холимог бүлгийн сургалтын арга зүйн чиглэлээр мэдээлэл хүргэх, чадваржуулах талаар анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Энэ асуудлыг шийдвэрлэх талаар МУБИС-ийн Багшийн сургуультай хамтран багшаар бэлтгэгдэж буй төгсөх ангийн 400 шахам оюутанд АББ-ын салбарын онцлог, үйлчилгээ, ДХС, түүнийг холимог бүлгээр хэрхэн зохион байгуулах талаар мэдээлэл өгч ажилласан болно. Цаашид тус сургуулийн сургалтын хөтөлбөрт энэ талаарх мэдээллийг суулгаж, багшаар төгсөж буй хүмүүст хүргэх нь ДХС-ын хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

за₁үүй’ £э’т₂э’: Өнөөдөр манай улсын их, дээд сургуулиудад АББ-ын чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин тусгайлан бэлтгэх тогтолцоо хараахан бий болоогүй, энэ чиглэлийн хичээл сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй байдаг учир АББ-ын багш нарын ур чадвар, аргазүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг АББЗСҮТ-өөс богино хугацааны сургалтын хэлбэрээр ихэвчлэн төсөл хэрэгжүүлэгч

⁷ “АББ-ын багшийн мэдээ”-2008 он

байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна. Тухайлбал, 2003-2007 оны хооронд АББ-ын аргазүйч, Гэгээрэл төвийн багш, төслийн бичиг үсгийн багш, багийн бага сургуулийн багш, хорих ангийн нийгмийн ажилтан, амьдрах ухаан, эрүүл мэндийн сургалт явуулдаг багш нар гэх мэт 2514 хүнд мэргэжил дээшлүүлэх болон АББ-ын багш бэлтгэх, туршлага солилцох уулзалт, сургалтуудыг явуулсанаас 380 хүнд “Албан бус боловсролын багш”-ийн үнэмлэх, давхардсан тоогоор 1000 гаруй хүнд сургалтанд хамрагдсаныг гэрчлэх сертификат олгосон байна. Гэвч АББ-ын багш нарыг бэлтгэх, давтан бэлтгэх, хамран сургах үйлчилгээ тогтмол биш зөвхөн төсөв хөрөнгийн бололцоотой үед зохион байгуулагдаж байгаа нь АББ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрэлдээгүй байгааг илтгэж байна.


5.3. ЭЦЭГ ЭХ, ОРОН НУТГИЙН ДЭМЖЛЭГ

Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь боловсрол эзэмшихэд эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцаа суралцагчдын хувьд тун чухал юм. Тиймээс сургалтын орчноос тусад нь бүлэг болгон авч үзэж байна.

“Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо” сэдэвт дүйцсэн хөтөлбөрөөр сурдаг болон сургууль завсардсан 500 гаруй хүүхэд, 1200 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан хийсэн судалгаа⁸ны зарим үр дүнгээс энд жишээ болгон авч үзье.

Эхлээд хүүхэд, залуус сургууль завсардах үедээ юу хүсэж, эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдээ сургуулиас гаргахгүйн тулд юу хийснийг зэрэгцүүлэн харъя (Зураг 5.18).

Зураг 5.18. Сургууль завсардсан хүүхдийн хүсэл ба эцэг эхийн дэмжлэг



Зургаас харахад, тухайн үед хүүхдийн хүсч байсан дэмжлэгийг эцэг эхчүүд тодорхой хэмжээгээр үзүүлж чадсан байна.


Тэгвэл нэгэнт завсардсанахаа дараа хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчаасаа юу хүсэж буйг сонирхвол, судалгаанд хамрагдсан хүүхэд, залуусын 82,4 хувь нь сурах сонирхолтойгоо илэрхийлж, тэдний 264 буюу 49,3 хувь нь гэр бүлийнхнээсээ одоо ч сурах боломж олгохыг, 123 буюу 23 хувь нь сэтгэл санааны дэмжлэгийг хүсдэг байна.

⁸ АББЗСУТ, Боловсролын хүртээмжийг дээшлүүлэхэд эцэг, асран хамгаалагчийн үүрэг оролцоо, УБ., 2009

Үүнтэй уялдаад тэднийг цаашид суралцуулах талаар эцэг, эх, асран хамгаалагчдын авсан арга хэмжээний талаар хүүхдүүд дараах хариултыг өгчээ (Зураг 5.19).

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуусын 324 буюу 60,4 хувийг эцэг, эх, асран хамгаалагчид нь АББ-ын болон бусад сургалтад хамруулж, 210 буюу 39,2 хувьд нь ном, сурах бичиг авч өгчээ. Мөн судалгаанд эрэгтэй хүүхэд түлхүү хамрагдсаныг тооцвол эцэг, эхчүүд охид, хөвгүүд гэж ялгалгүй адил хандсан нь зургаас тодорхой байна.

Зураг 5.19. Эцэг, эх, гэр бүлээс сургууль хүүхэддээ үзүүлж буй дэмжлэг хүйсээр



Эдгээрээс дүгнэлт хийхэд, үр хүүхэддээ санаа тавьдаг эцэг эхчүүд байхад тэдний сурлага, ирээдүйд анхаарал хандуулдаггүй нь ч бас байна. Хүүхдийн хүсэж байсанчлан түүнийг сургуулиас завсардуулахгүйн тулд дунджаар 43 хувийнх нь эцэг эх, асран хамгаалагч нь сургуулийн захирал, эрхлэгч, багштай нь уулзан, сэтгэл санаагаар дэмжиж, хичээлийн хэрэглэл авч өгсөн байна. Тэгсэн хэдий ч тухайн үед хүүхэд нь сургуулиас завсардсан нь ар гэрийн гачигдал, хүүхдийн эрүүл мэндийн байдал, сурлагадаа тааруу, эсвэл сурах дургүйтэй холбоотой болох нь судалгааны дүнгээс харагдав. Харин судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 60,4 хувь нь боловсрол нөхөн эзэмшихээр АББ-ын сургалтад хамрагдсан нь сайшаалтай. Оролцогчдын 12,1 хувь нь эцэг эх нь дэмий санаа зовохоос хэтрэхгүй болон тусалж чадахгүй гэснээс үзэхэд амьдралын нөхцөл, боломжоос шалтгаалж хүүхэддээ үнэхээр тусалж чадахгүй байна. Гэхдээ дийлэнх хувьд эцэг эхчүүд нь хүүхэддээ туслахыг хичээж байгааг зөв чиглүүлэн, хэрэгцээт мэдээллээр хангавал эцэг эхчүүдийн хүүхэддээ үзүүлэх дэмжлэг нэмэгдэн, энэ нь хүүхдийнх нь цаашдын хувь заяанд эерэгээр нөлөөлж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуус тухайн үедээ эцэг эхээсээ гадна сургууль, багш, орон нутгийн удирдлагаас юу хүсэж, тэд ямар дэмжлэг үзүүлснийг хүүхдийн хариулттай зэрэгцүүлэн авч үзье (Зураг 5.20).

Зураг 5.20. Хүүхдүүд багш удирдлагаас хүссэн зүйл ба тэдэнд үзүүлсэн дэмжлэг



Зургаас судалгаанд хамрагдагчдын 231 буюу 43,1 хувь нь эцэг эхэд нь зөвлөгөө өгүүлэх, 136 буюу 25,4 хувь нь хичээлийн хэрэглэл үнэгүй авах, дунджаар 73 хүүхэд буюу 13,6 хувь нь гэрийн багшаар заалгах, бичиг баримттай болоход нь сургууль, багш, орон нутгийн удирдлагаас тусламж үзүүлээсэй хэмээн хүсч байна. 15-аас доош насныхан үнэгүй хичээлийн хэрэглэл, эмчилгээний зардал авахыг илүүтэйгээр хүсдэг байна.

Хүүхдүүдийн хүссэн дэмжлэгийг сургууль, багш, удирдлагын зүгээс үзүүлсэн нь зураг 6.4-аас харагдаж байгаа ч дэмжлэг үзүүлээгүй гэж хариулсан хүүхдийн тоо багагүй хувийг эзэлжээ. Сургуулийн гадна буй хүүхэд, залууст боловсрол нөхөн олгох нь үйл ажиллагааных нь нэг чиглэл болдог АББ-ын Гэгээрэл төвийн талаар хүүхэд, залуусын 399 буюу 74,4 хувь нь мэддэг, 332 буюу 61,9 хувийнх нь гэр бүлийнхнээс уг төвийн сургалтад хамрагдан сэтгэл хангалуун байдгийг дурджээ.

АББ-ын Гэгээрэл төвд суралцдаг буюу суралцаж байсан хүүхдүүдийн эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлд нь туслах байдлаар багш нартай хамтран ажилладаг гэж оролцогчдын 311 буюу 58 хувь нь үзэж байна. Дунджаар 7 хувь нь л анги танхим, орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хүүхдүүдийн дунд ажил зохион байгуулахад эцэг эх нь тусалдаг гэжээ. Харин нийт оролцогчдын 140 буюу 26,1 хувь нь эцэг эхийгээ Гэгээрэл төвийн багш нартай хамтран ажилладаггүй гэж хариулснаас үзэхэд эдгээрийн дотор Гэгээрэл төвийн талаар мэддэггүй болон хүүхэд нь тус төвд суралцдаг хэдий ч эцэг, эх нь хол амьдардаг, ажил ихтэй завгүй, боловсрол багатай, идэвх санаачлагагүй зэрэгтэй холбоотой байна.

Сургуулийн гадна буй хүүхэд, залууст зориулсан үйл ажиллагааг орон нутгийн бусад байгууллагуудаас хэр их зохион байгуулдагийг авч үзье (Хүснэгт 5.9).

Хүснэгт 5.9. Байгууллагуудаас зохиодог үйл ажиллагааны давтамж (тоогоор)

Давтамж	Мэдэх-гүй	Огт зохиодоггүй	Жилд цөөн удаа	Сард цөөн удаа	7 хоногт цөөн удаа	Өдөр бүр
Байгууллагын нэр						
Баг(хороо)	381	70	45	9	13	18
Номын сан	374	68	24	18	35	17
Сургууль	350	50	36	20	23	57
Албан бус боловсролын төв	155	12	49	68	65	187
Аж ахуйн нэгж	425	56	35	14	3	3
Олон улсын байгууллага	386	46	81	7	7	9

Хүснэгтээс харахад, орон нутгийн засаг, захиргааны, соёлын байгууллага, сургууль, аж ахуйн нэгжээс сургуулийн гадна буй хүүхэд, залууст чиглэсэн үйл ажиллагааг хүртээмжтэй байдлаар зохион байгуулдаггүй нь ажиглагдаж байна.

Нөгөө талаас, сургуулийн гадна буй хүүхэд залуус өөрсдөө тэр бүр эдгээр байгууллагуудаар очиж үйлчлүүддэггүй, АББ-ын сургалтад хамрагдаж байгаа хүүхэд, залуус л Гэгээрэл төвөөс тэдэнд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулдаг, очиж үйлчлүүлдэгээ илэрхийлсэн байхад хамрагдаж чадаагүй хэсэг нь АББ-ын төв төдийгүй бусад байгууллагын талаар тодорхой мэдээлэлгүй нь судалгааны дүнгээс харагдаж байна (Хүснэгт 5.10).

Хүснэгт 5.10. Сүүлийн 12 сард хүүхэд, залуусын очиж үйлчлүүлсэн газар (тоогоор)

Үйлчилгээний газар	Давтамж	Байдаггүй	Огт очдоггүй	Жилд цөөн удаа	Сард цөөн удаа	7 хоногт цөөн удаа	Өдөр бүр
Сургууль		19	273	46	37	28	133
Албан бус боловсролын ГТ		10	148	44	42	46	246
Соёлын төв		18	344	93	43	27	11
Баг/ хороо		2	512	11	8	3	0
Номын сан		36	348	56	30	49	17
Ном, хэвлэл борлуулдаг цэг		34	403	52	18	17	12

Иймд орон нутгийн удирдлага үүнд анхаарч, баг, хороогоор дамжуулан иргэдийнхээ бүртгэлийг бодитой гарган, тэдэнд хэрэгцээт мэдээлэл, үйлчилгээг хүргэхэд захиргааны, сургалтын, үйлчилгээний болон аж ахуйн нэгж зэрэг бусад байгууллагын үйл ажиллагааг зангидан, удирдан чиглүүлж, хамтарч ажиллах хэрэгтэй байна.

Ийнхүү дүйцсэн хөтөлбөрт хамрагддаг суралцагчдын зүгээс тэдний боловсрол эзэмших үйл ажиллагаанд эцэг эх, орон нутгийн удирдлагын оролцоо, дэмжлэгийг дээрх байдлаар үнэлсэн бол АББ-ын Гэгээрэл төвийн багш нарын хувьд үүнийг хэрхэн авч үзсэнийг энд бас авч үзье.

АББ-ын багш нарын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа болон мэргэжил, арга зүйн хөгжилд тохиолдож буй бэрхшээлийг эзлэх хувиар нь эрэмбэлбэл сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг, ажлын байрны нөхцөл хүнд, эцэг эхийн дэмжлэг муу гэх бэрхшээлийг эхний гуравт нэрлэжээ (Зураг 5.21).

Зураг 5.12. Багш нарын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн хөгжилд тохиолдож буй бэрхшээл




Зураг 5.22. АББ-ын багш нар эцэг эхийн хамтын ажиллагаа, хувиар



АББ-ын Гэгээрэл төвийн багш нар, эцэг эхийн хамтын ажиллагаанд эцэг эхийн хурал хэмээх уламжлалт хэлбэр зонхилж, хүүхэд, эцэг эхэд зориулсан гарын авлага бэлтгэж хүргэх ажил багахан хувийг эзэлж байна (Зураг 5.22).

Хүүхдийн хичээл сурлагад дэмжлэг үзүүлэх, тэдэнд тохиолдож буй бэрхшээл зөрчлийг шийдвэрлэх, чөлөөт цагийг нь үр өгөөжтэй өнгөрүүлэх, хүмүүжүүлж төлөвшүүлэх, анги, сургуулийн орчныг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх чиглэлээр багш нар эцэг эхтэй хамтран ажилладаг ба энэ ажлын үр дүн нь хангалттай сайн гэхээргүй байна (Зураг 5.23).


Зураг 5.23. АББ-ын багш, эцэг, эхийн хамтын ажиллагааны үр дүн, хувиар



Суралцагчдын чөлөөт цагийг үр өгөөжтэй өнгөрүүлэх чиглэлээр хамгийн хангалтгүй хамтарч ажилласан байна. Сургууль завсардаад удсан хичээл номоос хөндийрсөн хүүхдүүдэд шууд цуглуулаад хичээл заахаас, нийгэм олон нийтийн дунд оруулах, уралдаан тэмцээн, аялал экскурс зохион байгуулах гэх мэт ажлаар эхлэх нь тэднийг татах нэг арга гэдгийг туршлагатай багш нар баталдаг. Харин газар дээрээ тэгж ажилладаг багш нар нь цөөн, суралцагчдын чөлөөт цагийг үр өгөөжтэй өнгөрүүлэхэд бага анхаардаг багш нар олон байна.

Багш нар, эцэг эх асран хамгаалагчийн оролцоог хангалттай дэмжиж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь эцэг эхийн идэвх санаачлага, гэр бүлийн амьдрал, боловсролоос ихээхэн хамааралтайг багш нар тэмдэглэсэн байна (Зураг 5.24).

Зураг 5.24. АББ-ын багш, эцэг, эхийн хамтын ажиллагаа хангалтгүй байгаа шалтгаан



Завсардсан хүүхэд боловсрол нөхөн эзэмших үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо дэмжлэг муу байдаг нь бэрхшээл учруулж байна. Хэдийгээр хүүхдийн хичээл сурлаганд дэмжлэг үзүүлэх, тэдэнд тохиолдож буй бэрхшээл, зөрчлийг шийдвэрлэх, анги танхим сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах зэрэг хэд хэдэн чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчтай хамтарч ажиллаж байгаа ч хангалттай үр дүнд хүрэхгүй байна.

ДХС-д хамрагдаж буй хүүхэд, залуусын дийлэнх хувь нь мал маллах, ар гэрийн гачигдал зэрэг шалтгааны улмаас сургуульд огт суугаагүй эсвэл завсардсан байсан нь зарим эцэг, эхчүүд хүүхдийнхээ боловсрол, ирээдүйд тавих анхаарал сул, нөгөө талаар хүүхдийнхээ туслалцааг авахаас өөр аргагүй болсон өрхүүд ч байгаатай холбоотой.

Түүнчлэн сурлага тааруу, сурах дургүй зэрэг шалтгаанаар сургууль завсардаж буй нь хүүхдийн сурах идэвхийг нэмэгдүүлэх, сургууль завсардуулахгүй байх, хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулах зэрэгт эцэг эх, багш, нийгмийн ажилтан хамтран ажиллах шаардлагатайг харуулж байна. Энд онцлон дурьдахад, бага насны хүүхэд сургуульд сурах эсэх талаар бие даан шийдвэр гаргах нь ховор тул эцэг, эхчүүдийн гаргах шийдвэрт эерэгээр нөлөөлөх бодит үйл ажиллагаа шаардлагатай байна.

Хүүхэд эцэг, эхээсээ үлгэр дууриал авч, тэднээс их суралцдаг тул эцэг эх, асран хамгаалагчдад хэрэгцээт мэдээллийг хүргэх, боловсрол эзэмших, суралцахын давуу талыг сурталчлах замаар хүүхдийн хөгжилд тэдний дэмжлэг оролцоог нэмэгдүүлэхэд баг/хороо, сургалтын болон бусад байгууллагыг татан оролцуулах, хамтарч ажиллах шаардлагатай байна. Цаашид эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд мөнгө санхүүгийн тусламжаас гадна эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэй ажиллах арга зүйн тусламж, сургалт, гарын авлага хэрэгтэй.

5.4. СУРГАЛТЫН ҮР ДҮН, ТӨГСӨГЧИД

ДХС-д хамрагддаг суралцагчдын сурлагын амжилтыг анги дэвшиж буй болон ЕБС-д шилжин суралцаж буй байдал, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж, гэрчилгээ авсан эсэхээр шууд үнэлж болно. Харин шууд бус буюу хэтийн үр дүнг тэдгээр суралцагчид сурч мэдсэнээ хэрэглэх замаар амьдралын чанараа дээшлүүлж байгаа эсэхээр дүгнэх юм. Шууд бус үр дүнг үнэлэх нь боловсролын үнэ цэнэ, өгөөжийг тогтооход хамгийн чухал боловч энэ талын мэдээллийг цуглуулахад бэрх байдаг.

Тиймээс энэ удаад ДХС-ын үр дүнг шууд буюу хэчнээн суралцагч ЕБС-д шилжсэн болон бага, суурь боловсрол эзэмшин, гэрчилгээ авснаар нь үр дүнг тодруулан авч үзье. БСШУЯ албан ёсоор ДХС-д хамрагдагчдын хэчнээн нь ЕБС-д шилжсэн, хэчнээн нь үргэлжлүүлэн суралцсан талаар мэдээлэл авдаггүйтэй холбоотойгоор энэ чиглэлийн дүн шинжилгээг АББЗСҮТ-ийн мэдээлэлд үндэслэн хийж байна.

ДХС-д хамрагдаж буй бага насны хүүхдүүдийг нас, мэдлэгийн түвшинд нь тохирох ЕБС-ийн ангид шилжүүлэн сургах бодлогыг барьдаг тул юуны өмнө энэ талаарх мэдээллийг авч үзье.

2006-2007 оны хичээлийн жилийн хувьд 8672 суралцагчийн **17.9%** нь ЕБС-ийн зохих ангид шилжин суралцсаны 10.4% нь бага, 7,4% нь суурь боловсролын түвшинд

суралцжээ. Бага боловсролын түвшинд шилжсэн суралцагчдын 51.2% нь эрэгтэй, 48.8% нь эмэгтэй байсан бол суурь боловсролын түвшний суралцагчдын 57,8% нь эрэгтэй, 42,2% нь эмэгтэй байна.

2007-2008 оны хичээлийн жилд 10398 хүн хамрагдсанаас **14.4** нь ЕБС-д шилжин суралцсан ба үүний 9,2 нь бага, 5.1% нь суурь боловсролын түвшинд хамрагджээ. Бага боловсролын түвшинд шилжсэн суралцагчдын 49,5% нь эрэгтэй, 50,5% нь эмэгтэй байсан бол суурь боловсролын түвшний суралцагчдын 50,2% нь эрэгтэй, 49,8% нь эмэгтэй байна.

2008-2009 оны хичээлийн жилд 12496 хүн хамрагдсанаас **11.5%** нь ЕБС-д, тодруулбал 6.1% нь бага, 5.4% нь суурь боловсролын түвшинд тус тус шилжин суралцжээ (Хүснэгт 5.11).

Хүснэгт 5.11

№	Хичээлийн жил	ДХС-д хамрагдсан	Үүнээс: ЕБС-д шилжин орсон								
			Бага			Суурь			Бүрэн дунд		
		Бүгд	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
1	2006-2007 он	8672	909	466	443	647	374	273	128	56	72
2	2007-2008 он	10398	967	479	488	533	268	265	141	63	78
3	2008-2009 он	12496	763	421	342	684	430	254	111	52	59
	Бүгд	31566	2639	1366	1273	1864	1072	792	380	171	209

ДХС-д хамрагдагсдын тоо жилээс жилд өсөж буй боловч ЕБС-д шилжин суралцагчдын түүнд эзлэх тоо, хувь багассаар байгааг хүснэгтээс харж болно.

Энэ нь тэдгээр суралцагчдын нас, мэдлэгийн түвшин ЕБС-ийн шилжих нөхцлийг хангах боломжгүй байгаатай холбоотой. Түүнчлэн ЕБС-д шилжин орох сэтгэл зүйн бэлтгэл хангагдаагүйтэй холбоотойгоор хүүхдүүд ихэвчлэн тус хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй байдаг аж.

Энэхүү сургалтын үр дүнд сүүлийн гурван хичээлийн жилд 4883 суралцагч буюу нийт суралцагчдын 15,4 хувь нь ЕБС-д шилжин орсон нь боловсрол эзэмших эрхийг хангахад ДХС чухал үүрэгтэйг харж болох юм. Гэвч сургалтын байгууллагуудын хөтөлбөр, төлөвлөгөөний залгамж чанар бага, АББ-ын үйлчилгээний чадавхи, эрх зүйн орчин нь албан сургалтын үйлчилгээтэй хамтран ажиллах түвшинд хүрээгүй зэрэг шалтгаан нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

2006-2007 оны хичээлийн жилийн байдлаар ДХС-д хамрагдсан нийт суралцагчдын 80,5%, 2007-2008 онд 84.2 %, 2008-2009 онд 87.5 % нь үргэлжлүүлэн суралцаж байна. (Хүснэгт 5.12).

Хүснэгт 5.12


№	Хичээлийн жил	ДХС-д хамрагдсан	Үүнээс ДХС-аар үргэлжлүүлэн суралцаж байгаа		
		Бүгд	Бүгд	Эр	Эм
1	2006-2007 он	8672	6988	5364	1624
2	2007-2008 он	10398	8757	6396	2361
3	2008-2009 он	12496	10938	8535	2403

ДХС-д үргэлжлүүлэн суралцагсдын тоо жилээс жилд ийнхүү 3,3-3,7 хувиар өссөн тоон үзүүлэлт харагдаж байгааг нэг талаас санхүүжилтийн асуудал тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдсэн, нөгөө талаас суралцагчдын идэвх, хандлага дээшилж байгаатай холбон ойлгож болно.

Үүнээс гадна ДХС-нд сүүлийн гурван жилд давхардсан тоогоор нийт 31566 суралцагч хамруулснаас үргэлжлүүлэн хамрагдаж буй суралцагчдын 76,05% нь эрэгтэй, 23,95% нь эмэгтэй байна.


Ийнхүү суралцагчид, тэдний суралцаж буй орчин, эцэг эх, олон нийтийн дэмжлэг, үр дүнг бүхэлд нь нэгтгэн дүгнэж үзвэл, ДХС чанар, хүртээмж хангалтгүй байна. Нэг талаас ДХС-д хамрагдагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа ч сургуулийн гадна буй хүүхэд, залуусын чухам хэдэн хувийг хамарч байгаа нь тодорхойгүй байна.

Түүнээс гадна санхүүжилтийн хэмжээ бага учраас суралцагчдын тоог хий өсгөх үзэгдэл байгаа нь уг сургалтын чанар, хүртээмжийг тодорхойлоход бэрхшээл учруулж байна. Нөгөө талаас сургалтын материал, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, башийн бэлтгэл, тогтвор суурьшилтай ажиллах байдал нь хангалтгүй түвшинд байгаа нь сургалтын чнарт шууд сөргөөр нөлөөлж байна.



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- 6.1. ДҮҮЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН**
- 6.2. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ЦААШИД АВАХ
АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ**



6.1. ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН ХҮРСЭН ҮР ДҮН

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын өнөөгийн хүрсэн түвшнийг дараах байдлаар дүгнэж байна:

- ДХС-ын агуулга тодорхойлогдож, үндэсний хэмжээнд баримтлах хөтөлбөртэй болсон нь хамгийн сайн тал юм.
- ДХ-ийн дагуу олон арван сургалтын материал боловсруулагдаж, сургалтад хэрэглэгдэж байна. Тухайлбал, 2004 онд ОУХБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхийн тулд АББ-ын чанар, хүртээмжийг дээшлүүлэх нь” төслийн үр дүнд суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн 7 багц номыг тус бүр 8500 ширхэг хэвлэн Гэгээрлийн төвүүдэлд түгээснээс заримыг нь казак хэл дээр орчуулсан нь одоо ч хэрэглэгдэж байна. 2005 онд батлагдсан дүйцсэн сургалтын хөтөлбөрийн дагуу 120 гаруй сургалтын модуль гарчээ.
- ДХС-ын арга зүй бий болов. Энэ хөтөлбөрөөр сургалт зохион байгуулдаг багш нар холимог бүлгийн арга зүйд суралцаж, тэдэнд зориулсан гарын авлага, зөвлөмж ч олон гарч хэрэглэгдэж байна. Тухайлбал, “Холимог бүлгийн сургалтын арга зүй”, холимог бүлгийн сургалтын модуль, холимог бүлгээр сургалт зохион байгуулах арга зүй” зэргийг дурдаж болно.
- ДХС-ын санхүүжилт тодорхой болов. Уг сургалтад хамрагдаж буй суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна (Боловсролын хуулийн 8.2 заалтын дагуу). 2009 онд дүйцсэн сургалтын хувьсах зардал нийт 1.4 тэрбум төг зарцуулсан бол 2010 онд 1.5 тэрбум зарцуулахаар төсөвт тусгагдаад байна.

6.2. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

Эдгээр ололттой тал байгаа боловч дүйцсэн сургалтын хувьд тулгамдаж буй, шийдлээ хүлээж буй асуудал олон байна. Эдгээрийг шийдвэрлэж болох хувилбар бүхий санал зөвлөмжийн хамт үзүүлье:

- Сургуулийн гадна буй хүүхэд, залуусыг ДХС-д хамруулах зохицуулалт хангалтгүй, сургалтын тогтолцоо институтчилагдаагүй, хүртээмж хязгаарлагдмал, үр дүнг тооцох эрх зүйн орчин, хяналт, үнэлгээний механизм бүрдээгүй байна. Гол зорилтот бүлэг болох малчдын хүүхдийн орон байр, хоол хүнсний хангамж зэрэг шийдэгдээгүй асуудал байсаар байна. Уг салбарт хуваарилагддаг хөрөнгө төсөв хомсдолтой байгаа нь гол бэрхшээл болж байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, ДХ-өөр боловсрол нөхөн олгох сургалтын тогтолцоог институтчлах шаардлагатай байна.

- Үүний тулд сургалтын явц, суралцагчийн боловсролд гарч буй ахиц, мэдлэг чадварын түвшинг үнэлж, хянах үзүүлэлт зэргийг боловсруулах, БСШУЯ-наас батлах замаар эхний алхмыг тавих нь зүйтэй.
- ДХС-ын талаарх мэдээлэл хангалтгүй, бодит бус байна. Мэдээллийг үнэн зөв, бодитой бүрдүүлэх, үүний хүрээнд албан ёсны мэдээлэл авах маягтуудыг боловсронгуй болгож батлуулах, мэдээлэл цуглуулах үүрэгтэй хүмүүсийг сургах, нэгдсэн сувгаар авах механизм бүрдүүлэх шаардлагатай. Одоо боловсруулаад буй АББ-ын мэдээллийн сангийн электрон программыг нэн даруй ашиглалтанд оруулах замаар мэдээллийн баазыг сайжруулах ажлыг хийх хэрэгтэй.
 - Мэдээлэл харилцааны технологи болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийг дүйцсэн сургалтад ашиглах явдал туйлын хомс байна. ДХС-ыг суралцагчдад чөлөөтэй, нээлттэй болгох, мэдээллийн технологийг ашиглах, онлайн хэлбэрт шилжүүлэх, үүний тулд төрөөс нэгдсэн зохицуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Ингэснээр ДХС болон АББ-ын салбарт үйлчилж буй эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт сайжирч, нийт хүн амд тасралтгүй, насан туршдаа суралцах боломжийг дэмжих хөшүүрэг болох болно.
 - ДХС-ын хүртээмжийг нэмэгдүүлэхэд эцэг эх, гэр бүл, олон нийт, орон нутгийн удирдлагын дэмжлэг оролцоог дайчлах, тэдэнд энэ талаарх мэдээ мэдээллийг түгээх, хамтарч ажиллах байдал хангалтгүй байна. Ялангуяа бодлого боловсруулагчид, сургууль, холбогдох байгууллага болон орон нутгийн удирдлагын оролцоо, дэмжлэгийг дээшлүүлэхийн тулд үр дүнгийн гэрээний нэг үзүүлэлт болгон оруулдаг журмыг мөрдүүлэх, багийн түвшинд ч мэдээллийг бодитой болгох талаар шат дараалсан арга хэмжээ авах шаардлагатай.
 - Гэгээрлийн төвүүдэд тоног төхөөрөмж, хэрэгсэл, сургалтын материал хүрэлцээгүй байгаа нь энэ салбарын үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, цар хүрээг хангаж чадахгүй байна. ДХС-ын чанар, хүртээмж нь зөвхөн хувьсах зардлаар шийдэгдэхгүй сургалтын орчинг сайжруулж, төрөл бүрийн материал боловсруулж гаргах, багш бэлтгэх, давтан бэлтгэхэд төрийн зүгээс хөрөнгө хуваарилдаг болгох талаар санаачлага гарган ажиллах шаардлагатай. Ялангуяа модуль боловсруулах, суралцагчдад хүртээмжтэйгээр хэвлэх, түгээхэд шаардагдах санхүүжилтийг БСШУЯ-ны сургалтын материалын зардалд суулгах хэрэгтэй. Түүнчлэн уг асуудлыг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болох Хүүхдийн сан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, Хөдөлмөрийн байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг чиглүүлэх замаар шийдвэрлэж болох юм.
 - АББ-ын бүх түвшний байгууллагуудын чадавхи сул, ялангуяа хүний нөөц, дутмаг байгаа нь ДХС-ын орчин бүрдүүлэх шаардлагыг хангаж чадахгүй байна. Мөн АББ-ын багш бэлтгэх тогтолцоо бүрдээгүй, цалин хөлс, нэмэгдэл зэрэг нийгмийн асуудал нь ЕБС-ийн багштай адил түвшинд шийдвэрлэгдэж чадаагүй байгаа нь сургалтын чанар, үр дүнд нөлөөлж байна. Иймээс ДХС-ыг инстиутчилах замаар багшийн цалин хөлс, нийгмийн халамжийн асуудлыг


нэг мөр болгон шийдвэрлэх шаардлагатай. Холбогдох их, дээд сургуулийн хөтөлбөрт ДХС-ын агуулгыг суулгах замаар багшийн бэлтгэлийн асуудлыг шийдвэрлэж болно.

- Албан болон албан бус боловсролын тогтолцооны уялдаа холбоо муу, зохицуулалт сул байна. Түүнчлэн хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага ДХС-ыг эрхлэн явуулж болох талаар журамд заасан хэдий ч энэ чиглэлээр ямар байгууллага, албан тушаалтанд хандаж зөвшөөрөл авах зэрэг үйл явцтай холбоотой тодорхойгүй асуудал байсаар байна. Иймээс төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хоорондох ажлын уялдаа холбоог дээшлүүлэх, зохицуулах механизмыг боловсронгуй болгоход БСШУЯ, харьяа газруудаас санаачлага гарган тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.
- ДХС-ын журмын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх замаар тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн шийдэл, хэрэгжүүлэх механизмыг тогтоох ажлыг тодорхой хугацаанд хийж байх шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- АББ-ын нөхцөл байдлын судалгаа, АББЗСҮТ, ЮНЕСКО, Улаанбаатар, 2009
- АББ-ын салбарын аймгуудын үйл ажиллагааны тайлан, 2007, 2008, 2009
- АББ-ын судалгааны дүн ба зөвлөмж, АББЗСҮТ, УБ., 2005
- АББЗСҮТ-ийн үйл ажиллагааны тайлан, УБ., 2008, 2009
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр, УБ., 2005
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам, БСШУЯ, УБ., 2007
- “Боловсрол” үндэсний хөтөлбөр, Монгол улсын Засгийн газар, УБ., 2010
- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо, Судалгааны тайлан, АББЗСҮТ, НҮБ-ын Хүүхдийн сан, УБ., 2009
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл, УБ., 2007, 2008, 2009
- БСШУЯ-ны үйл ажиллагааны тайлан, 2008, 2009
- Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, УБ., 2008
- Монголын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, Монгол улсын засгийн газар, УБ., 2006
- Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ, УБ., 2008
- Монголын хүүхдийн хөдөлмөрийн эрхлэлтийн байдал, Судалгааны тайлан, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөр, Үндэсний статистикийн хороо, УБ., 2008
- Мянганы хөгжлийн зорилтуудын үндэсний илтгэл, УБ., 2007
- Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн суурь боловсролын хүртээмжийн судалгаа, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөр, УБ., 2008

-
- Annual reports ADRA and World vision in Mongolia, 2008-2009
 - Education for All, Global Monitoring Report, Literacy for Life. UNESCO, 2006
 - Final Reports for Regional Seminars on Equivalency programme, APPEAL, UNESCO Bangkok, Manila, the Philippine, 2006
 - Final Reports for Regional Seminars on Equivalency programme, APPEAL, UNESCO Bangkok, Jakhur, India, 2007
 - Final Reports for Regional Seminars on Equivalency programme, APPEAL, UNESCO Bangkok, Indonesia, 2009
 - Global Report on Adult Learning and Education. UNESCO, 2009 <http://www.unesco.org/en/confinteavi/grale/>
 - National Report on Adult Learning and Education, Mongolia, National Centre for Non Formal and Distance Education, Ministry of Education, Culture and Science, Mongolia, Ulaanbaatar, 2009 <http://www.unesco.org/en/confinteavi/grale/>
 - Non Formal Education Sector Analysis of Mongolia. National Centre for Non Formal and Distance Education, Ministry of Education, Culture and Science, Mongolia, Ulaanbaatar, 2009



ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ – I

**ДХС – ТАЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ЭРХЗҮЙН БАРИМТ БУЧГИЙН
ЖАГСААЛТ**

ХАВСРАЛТ – 2

**ДХС – ЫН МАТЕРИАЛ, ГАРЫН АВЛАГА, БАГШ НАРТ ЗОРУУЛСАН
АРГА ЗҮЙН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

ХАВСРАЛТ – 3

**БАГШИЙН ЖУРНАЛ, ЯВЦЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БҮРТГЭЛ,
СУРАЛЦАГЧИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ**

ХАВСРАЛТ – 4

СУРАЛЦАГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ



НАВСРАЛТ—I

ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БУЧГИЙН ЖАГСААЛТ

*	Бодлого, хөтөлбөрийн нэр (хугацаа)	Шийдвэрийн түвшин (огноо)	Үндсэн зорилт	Стратеги, үйл ажиллагаа
1	Монгол улсын үндсэн хууль	1992.01.13	Хүн бүр суралцах эрхтэй, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгох	-
2	Боловсролын тухай хууль	Улсын Их хурал 2002.05.03	Боловсролын тогтолцооны нэг хэсэг нь АББ болохыг хуульчилж, АББ-ын байгууллагуудын ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх бусад бодлого, хөтөлбөрийг боловсруулах, эрэгжүүлэх үндэс болгох	- АББ-ын эрх зүйн үндсийг хуульчилж өгсөн - АББ-ын тогтолцоог бодлогын түвшинд хүлээн зөвшөөрсөн - АББ-ын арга хэлбэр, байгууллагын статусыг тодорхой болгосон
3	Бага боловсролын дүйцсэн хөтөлбөр	БСШУ-ны сайдын 2001 оны 159 тоот тушаал	Дүйцсэн хөтөлбөрөөр бага боловсрол нөхөн олгоход баримтлах эрх зүйн орчин бүрдүүлэх	- Хүн амыг бичиг үсэгт сургах, сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулах
4	Суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр	БСШУ-ны сайдын 2001 оны 283 тоот тушаал	Суурь боловсролын стандартын түвшинд боловсрол олгох, амьдрал хөдөлмөр, дараагийн шатны сургалтанд бэлтгэх	- Суурь боловсролын стандарт хангасан бол суурь боловсролын гэрчилгээ олгох
5	Гэгээрлийн төвийн үлгэрчилсэн дүрэм	БСШУ-ны сайдын 2003 оны 169 дугаар тушаал	АББ-ын Гэгээрлийн төвийн үйл ажиллагааг зохицуулах	- Удирдлага, зохион байгуулалт - Эрх үүрэг - Санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан
6	АББ, зайны сургалтын арга зүйчдийн ажлын байрны тодорхойлолт	БСШУ-ны сайдын 2003 оны 169 дугаар тушаал	АББ-ын аргазүйчдэд тавигдах шаардлага, ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааг зохицуулах	- Албан тушаалын чиг үүрэг, шаардлага, нөхцөл - Ажлын байрны онцлогийг тусгасан
7	Гэгээрлийн төвийн АББ-ын багшийн ажлын байрны тодорхойлолт	БСШУ-ны сайдын 2003 оны 169 тоот тушаал	АББ-ын Гэгээрлийн төвийн багш нарт тавих шаардлага, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	- Албан тушаалын чиг үүрэг, шаардлага, нөхцөл - Ажлын байрны онцлогийг тусгасан
8	Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр	БСШУ-ны сайдын 2005 оны 358 тоот тушаал	ДХС-аар бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх	- ДХС-аар бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж болох нөхцөл - ДХС-ын модулан бүтэц
9	Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө	Засгийн газрын 2006 оны 192 дүгээр тогтоол	“Албан бус ба насанд хүрэгчдийн боловсрол” гэсэн дэд хэсэгт ДХС-ын хүрээнд чанар, хүртээмж, цаашдын зорилтыг тодорхойлсон	- Үйл ажиллагааны зорилтууд тодорхойлогдсон - Санхүүжилтийн механизм тодорхой болсон
10	Боловсролын тухай хууль	Нэмэлт, өөрчлөлт, 2006	ДХС-аар бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлж болох тухай, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тогтоосон	- Хувьсах зардлаар санхүүжүүлэх замаар ДХС-ыг дэмждэг болсон
11	Бага, суурь, бүрэн дунд боловсролыг ДС-аар олгох сургалтын журам	БСШУ-ны сайдын 2007 оны 362 тоот тушаал	ДХС-аар бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх харилцааг зохицуулах	- ДХС-ыг АББ-ын Гэгээрлийн төвөөс шаардлага хангасан хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж явуулж болохыг тусгасан

ХАВСРАЛТ—2

ДХС—ЫН МАТЕРИАЛ, ГАРЫН АВЛАГА, БАГШ НАРТ ЗОРИУЛСАН АРГА ЗҮЙН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Нэр	Он
НЭГ. АББ-ЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР		
1	Албан бус боловсролын тогтолцоо	1998
2	Албан бус сургалтад сургалтын модуль хэрэглэх аргазүйн зарим асуудал, Д.Гүндэгмаа	2001
3	Албан бус боловсролын тогтолцоог бүрэлдүүлэн төлөвшүүлэх нь	2001
4	Албан бус боловсролын багшийн гарын авлага	2002
5	Албан бус боловсролоор үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд	2003
6	Боловсролын шинэчлэл, Х. Дүгэр	2001
7	Насанд хүрэгчдэд зориулсан сургалтын материал орон нутагт бэлтгэх гарын авлага	2002
8	Нээлттэй сургалтын онол, аргазүй, Х.Дүгэр	2003
9	Монгол улсад албан бус боловсролын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх онол, арга зүйн асуудалд	2001
ХОЁР. ЗАЙНЫ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
10	Албан бус боловсролын багшид зориулсан зайны сургалтын материал (видео хуурцагтай)	2003
11	Албан бус боловсролын зайны сургалтын материалууд	2007
12	Англи хэлний зайны сургалтын багшийн зөвлөмж, Н.Мира нар	2003
13	Билгийн нүд-1	2006
14	Зайны сургалтын сурах бичиг зохиогчдод зориулсан зөвлөмж, Д.Гүндэгмаа	1999
15	Зайны сургалтын онол, арга зүйн асуудлууд	2000
16	Зайны сургалтын менежмент, Ц.Ундрах	2001
17	Зайны сургалтын видео хичээл 1, 2, 3	2006
18	Зайны сургалтын видео хичээл 4, 5, 6	2006
19	Ноосоор урлахуй	2008
20	Ноос цагаан алт	2008
21	Оюун тэлэхүй	2006
22	Тахиа шувуу ашигтай даа..	2007
23	Хотон бий биелгээ	2008
24	Хүсвэл хог биш	2008
25	Learn English yourself (аудио болон радио хичээлийн хамт) Н.Мира нар.	2003
ГУРАВ. ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛЭЭР		
3.1 БАГА БОЛОВСРОЛ		
26	Газрын шимийг хүртье, С.Чимгээ	2000
27	Нарны цацраг, Г.Лхаахүү	2000
28	Математик, Б.Балдулам нар	2000
29	Математикийн бодлого, дасгалууд	2000
30	Мал аж ахуй, Н.Эрдэнэцогт	2000
31	Математик	2004
32	Монгол хэлний сурах бичиг, С.Ганболор нар	2000
33	Монгол хэлний дасгалууд, С.ганболор нар	2000
34	Монгол хэл	2004
35	Уран зохиолын сурах бичиг, С.Ганболор нар	2000
36	Унших бичиг, Д.Туяа	2000

37	Хүн болох багаасаа, Д.Гүндэгмаа	2000
38	Хүн, байгаль, нийгэм, Ё.Нямдаваа нар	2000
3.2. СУУРЬ БОЛОВСРОЛ		
39	Байгалийн ухаан, Ц.Содов нар	2001
40	Зураг төсөл, урлан бүтээх ажил, Д.Хөхөө нар	2001
41	Орос хэл, Д.Гүндэгмаа нар (аудио хуурцагтай)	2001
42	Нийгмийн ухаан, Ё.Нямдаваа нар	2001
43	Математик, мэдээлэл зүй, Х.Дүгэр нар	2001
44	My first English (аудио хуурцагтай)	2001
45	Монгол хэл, уран зохиол, Ш.Оюунцэцэг нар	2001
3.3 БАГА БОЛОВСРОЛЫН ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ		
46	Англи хэлээр ярьцгаая, С.Гансүх, Д.Чулуунцэцэг	2007
47	Ахуйн тооцоо, О.Чулуунцэцэг	2008
48	Байгалийн сонин хачин, Г.Жавзанхорлоо, Ц.Намчинсүрэн	2008
49	Байгалийн гамшиг, С.Дуламдорж	2008
50	Банкны хүү, Б.Эрдэнэчимэг, Ц.Лувсандорж, Ч.Ганцэцэг	2008
51	Би - миний гэр бүл, С.Гансүх	2007
52	Би-миний орчин, У.Туяа, Н.Алтангэрэл	2007
53	Би бол ..., З.Тогтохмаа	2006
54	Бидний эргэн тойронд, Г.Жавзанхорлоо, Ц.Намчинсүрэн	2007
55	Би монгол хүн, Т.Хантулга	2007
56	Бизнес тооцоо, Б.Эрдэнэчимэг, Ц.Лувсандорж, Ч.Ганцэцэг	2008
57	Бүтээлч тооцоо, Т.Ганбаатар, Э.Чойсүрэн	2008
58	Дүрэм бидний амьдралд, У.Туяа	2007
59	Дүрсийн гайхамшиг, С.Ундрал, Б.Батсүрэн	2007
60	Зөв хооллолт, Т.Хантулга	2008
61	Математик хэл харилцаа, О.Чулуунцэцэг, Б.Эрдэнэчимэг	2007
62	Миний бие махбод, С.Эрдэнэчимэг	2007
63	Миний мэдрэмж зургаар, Д.Хөхөө	2006
64	Миний урлан, Д.Хөхөө	
65	Нэмэх хасах, Б.Эрдэнэчимэг, Ц.Лувсандорж, Ч.Ганцэцэг	2007
66	Нэмэх хасах II, Б.Эрдэнэчимэг, Ц.Лувсандорж, Ч.Ганцэцэг	2007
67	Оновчтой шийдвэр, Б.Эрдэнэчимэг, Б.Мөнхнасан	2007
68	Өсөхөөс сурсан үндэсний хэл I, Б.Булган	2007
69	Өсөхөөс сурсан үндэсний хэл II, Ш.Оюунцэцэг	2007
70	Өвөл зун, өдөр шөнө, Т.Навчаа, Г.Юмчмаа	2006
71	Тэвдэж явахад..., З.Тогтохмаа, Ч.Байгалмаа	2007
72	Тэнгэрийн ааш, Т.Навчаа	2006
73	Статистик бүртгэл тооцоо, Д.Энхцэцэг, Б.Мөнхнасан	2007
74	Үржих хуваах, Б.Эрдэнэчимэг, Ц.Лувсандорж, Ч.Ганцэцэг	2007
75	Харилцаа, Н.Цэгмид, У.Туяа	2007
76	Харилцах хөтөч, П.Энхжаргал	2007
77	Хүн хэлээрээ I, Ц.Наранцэцэг	2006
78	Хүн хэлээрээ II, Д.Гүндэгмаа	2006
79	Хөдөлгөөн бидний амьдралд, Г.Жавзанхорлоо, Ц.Намчинсүрэн	2007
80	Хожил хожигдол, Б.Эрдэнэчимэг, Ч.Ганцэцэг	2007

81	Холбоо хамаарал, Д.Энхцэцэг	2007
82	Хэмжүүр, С.Ундрал, С.Отгонбаяр	2006
83	Хэмнэл хөдөлгөөн, С.Ундрал, Б.Батсүрэн	2007
84	Хэл сэтгэл, Д.Гүндэгмаа, С.Эрдэнэсан	2007
85	Цайны соёл, Г.Баярмаа	2007
86	Эрүүл биед саруул ухаан, С.Ундрал	2008
87	Эрүүл хүнс, Т.Оюун	2007
88	Эрүүл орчин —Энх амьдрал, Д.Мөнхжаргал, З.Тогтохмаа	2008
89	Эх хэл эрдмийн түлхүүр, Д.Гүндэгмаа	2007
3.4 СУУРЬ БОЛОВСРОЛЫН ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ		
90	Ахуйн тооцоо, О.Чулуунцэцэг	2008
91	Амьдрал урвал хөдөлгөөн, Ц.Сумъяа	2008
92	Амьтан бидний амьдралд, Д.Суран, Х.Гэрэлмаа	2008
93	Банкны хүү, М.Итгэл	2008
94	Баатарлаг үйлс, Т.Хантулга, Г.Шүрэнцэцэг	2008
95	Байгалийн сонин хачин, Г.Жавзанхорлоо	2008
96	Бодис бидний амьдралд, Ц.Сумъяа	2008
97	Бүтээлч тооцоо, Д.Ганбаатар, Э.Чойсүрэн	2008
98	Бидний эргэн тойронд, Б.Бурмаа, Б.Батцэцэг, А.Дулмаа	2008
99	Бидний түүхийн улбаа I, О.Пүрэв	2007
100	Бидний түүхийн улбаа II, О.Пүрэв	2007
101	Гурвалжны гайхамшиг, У.Доёд, Ц.Далайжамц	2008
102	Дүрсийн гайхамшиг, У.Доёд, Ц.Далайжамц	2007
103	Математик хэл харилцаа, Б.Эрдэнэчимэг, Б.Мөнхнасан	2008
104	Монголчуудын зуун, У.Туяа	2008
105	Миний урлан, Д.Хөхөө	2007
106	Миний бие махбод, С.Эрдэнэцэцэг	2007
107	Нүд амьдрал, Б.Бурмаа, Б.Батцэцэг, А.Дулмаа	2008
108	Нэмэх хасах, Б.Эрдэнэчимэг, Ч.Ганцэцэг	2008
109	Оновчтой шийдвэр, Б.Эрдэнэчимэг	2008
110	Өвчингүй бол жаргал, Э.Мөнгөтулга	2008
111	Өвөл зун, өдөр шөнө, Ц.Одгэрэл	2008
112	Өрхийн төсөв тооцоо, Т.Хантулга, Б.Эрдэнчимэг	2007
113	Өсөхөөс сурсан үндэсний хэл I, Б.Булган, Д.Төмөрсүх	2007
114	Өсөхөөс сурсан үндэсний хэл II, Ш.Оюунцэцэг	2007
115	Өсөхөөс сурсан үндэсний хэл II зохион найруулахуй, Д.Гүндэгмаа, Д.Эрдэнэсан	2008
116	Сайн эзний мал эрүүл, С.Ундрал	2007
117	Статистик бүртгэл тооцоо, Д.Энхцэцэг, Б.Мөнхнасан	2007
118	Сүлжээний бизнес, М.Итгэл	2008
119	Та ажил эрж байна уу?, З.Тогтохмаа	2007
120	Тэнгэрийн ааш, Т.Навчаа	2008
121	Уран зохиол, Ш.Оюунцэцэг, Чимгээ	2008
122	Ургамлын ач тус Д.Суран, Х.Гэрэлмаа	2008
123	Уур амьсгал, Т.Навчаа	2008
124	Ус чандмань эрдэнэ, Ц.Одгэрэл	2008
125	Үржих хуваах, Б.Эрдэнэчимэг, Ч.Ганцэцэг	2008

126	Харилцах хөтөч, П.Энхжаргал	2007
127	Хууль бидний амьдралд, У.Туяа	2006
128	Холбоо хамаарал, Д.Энхцэцэг, Ж.Чогмаа	2008
129	Хүн хэлээрээ-I, Д.Гүндэгмаа, Д.Эрдэнэсан	2008
130	Хүн хэлээрээ-2, Д.Баттогтох, Д.Гүндэгмаа	2008
131	Хөдөлгөөн бидний амьдралд, Г.Жавзанхорлоо	2008
132	Хэл сэтгэл, Д.Гүндэгмаа, Д.Эрдэнэсан	2008
133	Цайны соёл, Г.Баярмаа	2008
134	Цэвэр усаа хэмнэе, Ц.Одгэрэл	2008
135	Эрүүл хүнс, Т.Оюун	2007
136	Эх хэл эрдмийн түлхүүр, Д.Гүндэгмаа, Д.Эрдэнэсан	2007
137	Эрдэс чулуу, Ц.Одгэрэл	2008
138	Эрүүл биед саруул ухаан, С.Ундрал	2008
139	Я и моя семья, Д.Гүндэгмаа	2007
3.5 БҮРЭН ДҮНД БОЛОВСРОЛЫН ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ		
140	Амьдрал тэмцэл, Т.Навчаа	2008
141	Банкны хүү, М.Итгэл	2008
142	Мэдээлэл аалзны тор, Л.Мөнхтуяа	2008
143	Нэмэх хасах, Ш.Мягмар	2008
144	Өсөхөөс сурсан үндэсний хэл-II, Ц.Өнөрбаян, Ц.Туул	2008
145	Хожил хожигдол, статистик бүртгэл, М.Итгэл	2008
146	Хөрс шороо, Т.Навчаа	2008
147	Хүн хэлээрээ-II, Ц.Өнөрбаян, Ц.Туул	2008
ДӨРӨВ. БУСАД		
148	Архи, амьдралын дэнс	1999
149	Байгалийн хишгийг хүртэцгээе	2000
150	Багш Та	1998
151	Бизнест суралцах анхны алхам	1999
152	Бизнес сургалтын дадлага ажлын ном	1999
153	Бод, оролд, бүтээ	2000
154	Газар эхийн өгөөж	1999
155	Гэр бүл, хүүхэд	1999
156	Зах зээлд суралцъя	1998
157	Зайны сургалтын материал бэлтгэх нь	1998
158	Зайны сургалт Монголд	1999
159	Иргэн ба хууль	1999
160	Мал эзнээсээ	1999
161	Монголын уламжлалт дээл хувцас	2000
162	Малын хишиг буян-1	2000
163	Малын хишиг буян-2	2000
164	Төсөл хэрэгжүүлэх тухай	1998
165	Урлахуйн ухаан	1999
166	Хүүхэдтэйгээ хамт	1999
167	Хүний эрх ба нутгийн өөрөө удирдах ёс	1999
168	Хүүхдийн эрүүл мэнд	2000
169	Хүүхдийн хүмүүжил	2000

170	Хүүхэдтэйгээ хамт	2000
171	Мэргэжлээ хэрхэн сонгох вэ	2003
172	Та үүнийг хийж чадна	2003
173	Та хүүхдээ анхааран сонсдог уу	2002
174	Та хүүхдээ анхааран сонсдог уу	2002
175	Төсөл хэрэгжүүлэх тухай удирдамж	2001
176	Сургалт зохион байгуулах удирдамж	2001
177	Хүүхэд Таны эрх I	2002
178	Хүүхэд Таны эрх II	2002
179	Хүүхдийн эрх, үүрэг, оролцоог дэмжихэд багш нарт зориулсан гарын авлага	2002
180	Хүүхдийг хөгжүүлэхэд зайны сургалтыг ашиглах нь	2002
181	Хүүхдийн ирээдүй, мэргэжил сонголт	2003
182	Арвайн гурил ч амттай даа..., Д.Хөхөө	2008
183	Болгоомжил!	2006
184	Гялгар уут хаягдал мөн үү?, С.Унрал, Б.Батсүрэн	2006
185	Ёс ёмбогор, Н.Уртнасан, Ц.Самдан	2008
186	Зөв зангидаж сурвал ч..., Д.Хөхөө, Б.Алтанцэцэг	2008
187	Нигшингэ бэлтгэх, Е.Батчулуун	2007
188	Миний өв биднийх ..., Ц.Самдан	2008
189	Таны биеийн жин хэвийн байна уу?	2006
190	Тамхи чимээгүй дайсан	2006
191	Тамхи-Утаан тахал	2008
192	Тогтвортой хөгжлийн боловсролын НҮБ-ын 10 жил (2005-2014)-ийн зорилтыг хэрэгжүүлэх олон улсын загвар	2006
193	Хог хаягдлыг дахин ашиглаж болох уу?, З.Тогтохмаа	2006
194	Хортон шавьж устгах...!, Т.Хантулга	2006
195	Хоол хүнсний зохистой хэрэглээ	2006
196	Элгээ хамгаалья	2006
197	Амьдрах ухааны хөтөлбөр	2008
198	Амьдралд хөл тавих нэгэн гүүр буюу таны оюуны чадамж, О.Мягмар	2008
199	Харилцааны саятан, О.Мягмар	2008
200	Хамгийн чухал зүйлийн талаар ярилцах уу?	2008
201	Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол, хөтөлбөр	2007
202	Багш танд	2006
203	Биеэ засаад гэрээ зас	2006
204	БЗДХ ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх нь	2006
205	Найз минь чи хичээгээрэй	2006
206	Хорт зуршлаас холхон амьдаръя	2006
207	Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	1997
208	Албан бус боловсролын Гэгээрлийн төвийн арга зүйчийн ажлын байрны тодорхойлолт	2003
209	Бага боловсролын дүйцсэн хөтөлбөр	2001
210	Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн журам	2007
211	Зайны сургалтын үндэсний хөтөлбөр	2002
212	Гэгээрлийн төвийн үлгэрчилсэн дүрэм	2003
213	Гэгээрлийн төвийн Албан бус боловсролын багшийн ажлын байрны тодорхойлолт	2003
214	Суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр	2001

215	Суурь боловсролын хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах зөвлөмж	2001
216	Албан бус боловсролын Гэгээрлийн төвийн төлөвлөлт, удирдлага	2004
217	Албан бус боловсролын ном, сурах бичгийн лавлагаа	2004
218	Албан бус боловсрол, зайны сургалтын баримт бичгийн эмхэтгэл	2003
219	Албан бус боловсролын мэдээллийн менежментийн тогтолцоо	2007
220	Амьдрах ухаан (хичээлийн хөтөлбөрийн хамт)	2004
221	Бүх нийтийн боловсролын асуудлууд	2004
222	Багийн сургуулиудын холимог бүлгийн сургалтанд хийсэн үнэлгээ	2003
223	Өсвөр насныхантай харилцах нь, О.Мягмар	2003
224	Холимог бүлгийн сургалтын арга зүй	2004
225	Холимог бүлгийн сургалт зохион байгуулах аргачлал	2004
226	Холимог бүлгийн сургалт Монголд	2004
227	Холимог бүлгийн сургалт дахь сургалтын модулиуд	2004
228	Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр	2004

НАВСРАЛТ—3

БАГШИЙН ЖУРНАЛ, ЯВЦЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БҮРТГЭЛ,

№	Суралцагчийн овог нэр	Нас, хүйс	Эцэг эхийн нэр, хаяг, утас	Суралцах түвшин	Гэрээ байгуулсан огноо	Биелэлт

ЯВЦЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БҮРТГЭЛ

Бүртгэлийн дугаар	Суралцагчийн нэр	Ирсэн огноо	Ажилласан цаг	Суралцаж буй түвшин, агуулга	Өгсөн даалгавар

СУРАЛЦАГЧИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

СУРАЛЦАГЧИЙН ЧАДВАРЫГ ХЯНАХ ХУУДАС

Чадварууд		Суралцагчийн нэрс									
ХАРИЛЦАХ АРГА УХААН											
Эх хэлнийхээ хууль дүрмийн дагуу амаар болон бичгээр соёлтой зөв харилцах											
Санаа бодлоо илэрхийлэхдээ уран яруу дүрслэлийн жишээ загварыг хэрэглэх											
Тэмдгэн болон дохионы хэлээр илэрхийлсэн мэдээллийг зөв ашиглах											
Хүн чанар, шударга зан, дууриалтай болон жигшилтэй явдлын талаар үзэл бодлоо илэрхийлэх, Өөрийн болон бусдын өмнө үүрэг, хариуцлага хүлээх											
Хууль, дүрэм, журмын тодорхой заалтуудыг тайлбарлах, зөрчигдсөн эрхээ сэргээхэд хүний эрхийн хуулиудыг ашиглаах											
Газрын зургийг ашиглан орон нутаг, улс орон, түүхэн үйл явдлын тухай тайлбарлан ярих, санал солилцох											
Түүхэн баримт, эх сурвалж, шинэ мэдлэгээ ашиглан өөрийн санаа бодлыг нотлох											
Математикийн нэр томьёо, схем, диаграмм, масштаб, тооцоолол ашигласан мэдээллийг ойлгох, учир үндэслэлтэй тайлбарлах											
Физик хэмжигдэхүүний энгийн холбоо, хамаарлыг үгээр, диаграммаар, томьёогоор илэрхийлэх, тайлбарлах											
Байгаль, нийгэм, орчин тойрны юмс, үзэгдэл, үйл явдлыг зураг дүрслэлээр зохиомжлон тайлбарлах											
Ажлын зураг болон проекц, байгуулалт, загвар, загварчлалын аргыг ашиглан мэдээлэл солилцох											
ЭРДЭМШИХ АРГА УХААН											
Байгаль, нийгэм, хүрээлэн буй орчны юмс үзэгдлийн холбоо хамаарлыг тодорхойлох											

Аливаа юмс, үзэгдэл, үйл явдлын бүрдэл хэсэг, ерөнхий шинж чанарыг задлан шинжлэх, харьцуулах, жиших, нэгтгэн дүгнэх, бүтээлч сэтгэлгээний арга барилыг эзэмших								
Аливаа юмс, үзэгдэл, үйл явдлын шинж чанар, уялдаа холбоог учирлан тайлбарлах, загварчлах								
Байгаль, нийгэм, хүрээлэн буй орчинд хүний эзлэх байр суурийг тодорхойлох, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх								
Амьгүй ба амьд байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтэц, ерөнхий шинж чанар, төлөв байдал, өөрчлөлт хувьсал, холбоо хамаарал, учир шалтгааныг тайлбарлах								
Амьд ба амьгүй байгалийн хоорондын холбоо хамаарлыг ухааран харьцах, өөрийн үйл ажиллагаандаа зүй зохистой хэрэгжүүлэх								
Байгаль, ахуй амьдралд тохиолдох материал, бодис, урвалжуудыг ажиглах, харьцуулах, ялган таних, тооцоолох, сорил туршилт явуулах энгийн арга барил эзэмших, зүй зохистой хэрэглэх								
Физик хэмжигдэхүүн, хууль, түүний энгийн холбоо хамаарлыг үгээр, диаграммаар, томъёогоор илэрхийлэх								
Компьютер болон ахуйн хэрэглээний цахим төхөөрөмжүүдтэй зааврын дагуу соёлтой харьцах								
Интернетээс хэрэгцээт мэдээллийг хайх, электрон шуудан хэрэглэх								
АМЬДРАХ АРГА УХААН								
Бие сэтгэхүйн онцлог талаа мэдэрч, түүнийгээ хөгжүүлэх, дутагдалтай талаа засах								
Эрүүл мэндээ сахин хамгаалах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах								
Өдөр тутам хэрэглэгддэг нөөц (гэрэл, дулаан, цахилгаан, илчлэг, температур гэх мэт)-д хэмнэлттэй ухамсартай хандах								
Сэтгэлийн хямралаас урьдчилан сэргийлэх, зохицуулах								

Ажил, амьдралаа төлөвлөн, зохион байгуулж сурах								
Амьдрал ахуйгаа дээшлүүлэхэд байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, юмхнаар юм хийх								
ИРГЭНШИХ АРГА УХААНЫ								
Өөрийн итгэл үнэмшилтэй байх, өөрийгөө илэрхийлэх, хүндэтгэх, бусдад ойлгуулах								
Хамтын шийдвэрт хүндэтгэлтэй хандах, шийдвэр гаргахад оролцооны ач холбогдлыг ойлгох								
Эх хэл, түүхээрээ бахархах, хамгаалах, хөгжүүлэх хандлагатай болох								
Хүний эрхийн зөрчлийг ялган таних, урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрх, эрх ашгаа сэргээлгэх эрмэлзэлтэй байх								
Дүрэм, журмыг мөрдөн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх хэрэгцээг ойлгох, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх соёлд суралцах								

ТАЙЛБАР:


Суралцагчдын чадвар эзэмших явцыг дараах тэмдэглэгээ ашиглан тэмдэглэнэ.

- А — сайн эзэмшсэн
- В — эзэмшсэн ч гүнзгийрүүлэх шаардлагатай
- С — эзэмшихийг хүсэж буй
- Д — эзэмшихийг хүсдэг ч одоо биш

НАВСРАЛТ-4

СУРАЛЦАГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ

СУРАЛЦАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА



Овог:

Нэр:

Төрсөн он, сар, өдөр:

Регистрийн дугаар:.....

Нас:.....

Хүйс:.....

Иргэншил:

Гэрийн хаяг:
.....

Гэр бүлийн байдал (ам бүл, гэрлэсэн эсэх, гэр бүлийн гишүүдийн ажил эрхэлдэг ажил):

.....
.....
.....
.....
.....

Ерөнхий боловсролын сургуульд сурч байсан эсэх:

.....
.....

Төгссөн анги:

.....
.....

Албан сургалтанд хамрагдаж байсан эсэх:

.....
.....

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

Шилжсэн аймаг, сум, дүүрэг:

.....
.....

Шилжих болсон шалтгаан:

.....
.....

20.... оны сарын өдөр

